

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

**“ Багшлах эрх олгох шалгалт”-ын бүтэц,  
агуулгын талаарх зөвлөмж боловсруулах дэд  
багийн ажлын тайлан.**

---

2013 оны 12-р сар

Дэд багийн ахлагч Б.Бурмаа

Гишүүд: Х.Тамир,  
С.Энхтүвшин,  
Д.Наранчимэг,  
Ж.Батдэлгэр

Улаанбаатар хот

## Өмнөх үг

Багшлах эрх олгох шалгалт нь хувь хүн болон нийгмийн хэрэгцээ шаардлага, өөр өөр ашиг сонрхолын огтолцол дээр байдаг чухал асуудал юм: Үүнд:

- Багш бэлтгэдэг их сургуулийн дипломтой, багшийн ажил хийх сонрхолтой олон арван залуучуудын ажлын гараа нь энэхүү шалгалтын үр дүнгээс хамаарах тул тэдний хувьд шалгалт боломжийн түвшинд хөнгөн байх нь тэдний сонрхолд нийцэх нь мэдээж.
- Гэвч боловсролын салбарын хувьд авч үзвэл илүү өргөн хүрээнд харах шаардлага гардаг. Шавийн эрдэм багшаас гэж манай ухаант ард түмэн ярьдаг. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг юуны өмнө багш нарын мэдлэг, чадвар, хандлага, ёс зүйтэй холбон авч үздэг. Өнөөдөр манайд олон тооны төрийн ба хувийн их, дээд сургуулиуд багш мэргэжилтэнг бэлтгэж, эдгээр сургуулийг төгөссөн багш нарын мэдлэг, чадвар харилцан адилгүй байна. Ер нь дипломтой болгон нь багш мэргэжилтэний мэдлэг чадвартай биш, багшийн ажил хийж буй хүн бүр багш мэргэжилтэн биш болох нь амьдрал дээр харагдаж л байдаг асуудал. Иймээс багшлах эрх олгох гол шалгуур нь энэ хүнд бакалавр, магистрын зэрэг байгаа эсэх, харгалзах дипломтой эсэхээр хязгаарлах нь учир дутагдалтай юм. Харин эдгээр дипломыг авсан хүн багш бэлтгэх их, дээд сургуулийг төгсөхдөө ямар мэдлэгтэй болсон байх ёстой вэ? Багш хүний алхам дутамд тохиолдох дидактик шийдлүүдийг хийхдээ энэхүү мэдлэгээ хэрэглэх чадварын цар хүрээ нь ямар байна вэ? Энэ хүнд багш мэргэжилтэнд байх ёстой эдгээр мэдлэг, чадварыг өөртөө шингээн цаашид хөгжих хувь хүний урьдчилсан нөхцөл байна уу гэх мэт шалгуурыг авч үзэх нь зүйтэй юм.

Ийм учраас багшлах эрх олгох шалгалтын бүтэц, агуулгаын талаар зөвлөлгөө боловсруулахын тулд юуны өмнө хэд хэдэн чиглэлээр судалгаа хийх нь зохилтой гэж шийдсэн юм. Судалгааны үр дүн болон түүнд тулгуурласан зөвлөмжийг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа. Үүнд:

- 1. Багш судлалын чиглэлээр орчин үед олон улсын түвшинд хэрэгжиж байгаа суурь судалгаануудыг судлаж тойм боловсруулах.** (Б.Бурмаа, Х.Тамир ба бусад)
- 2. Багшийн эрх олгох шалгалт эрх зүйн орчинг бүрдүүлэх, шалгалтын бүтэц, агуулгатай холбоотой асуудлуудаар гадаад орнуудын туршлага судлах. Шаардлагатай бичиг баримтуудыг орчуулах.** (С.Энхтүвшин, Д.Наранчимэг, ба бусад)
- 3. Багшлах эрх олгохтой холбоотой эрх зүйн орчинд хийсэн судалгаа:** (Х.Тамир ба бусад)

**Судалгаа 1: Орчин үед багш судлалын чиглэлээр олон улсын түвшинд хэрэгжиж байгаа суурь судалгаануудыг судалж багшийн эрх олгох шалгалтын агуулганд баримжаа болгох асуудлуудыг сонгон тойм боловсруулан зөвлөмжд тусгах.**

### **Удиртгал:**

Чадварлаг багшийг бэлтгэх нь багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын чухал зорилтын нэг бөгөөд энэ нь нийт боловсролын системийн хувьд стратегийн ач холбогдолтой байдаг. Багш нь хичээл, сургалтын ажлын гол мэргэжилтэн байсан, одоо ч байгаа, цаашдаа ч байх нь мэдээж. Тэгвэл багшийн хөгжил, тэдний шинэ дүр зургийн талаар авч үзэх хэрэг байна уу? гэсэн асуулт гарч болох юм. Бидний амьдарч буй нийгэм, үнэт зүйлийн үнэлэмж, боловсрол гэсэн ухагдахуун хүртэл өөрчлөгдөж байгаа болохоор багшийн хөгжлийн талаар ярих шаардлага зүй ёсоор гарч ирдэг. Тухайлбал их сургуулиар бэлтгэж буй ирээдүйн багш нар суралцах явцдаа ямар мэдлэг, чадвар эзэмших ёстой вэ? Ийм мэдлэг чадвартай болсныг нь яаж үнэлэх вэ? гэдэг асуудал нь боловсролын шинжлэх ухааны судалгаа болон хичээл сургалтын бодит амьдрал дээр чухлаар тавигдах болсон байна. Ийм учраас энэ чиглэлээр дэлхийн түвшинд хийгдэж байгаа судалгааны материалуудыг судалж, боловсролын салбарын судалгаа болон сургалтын үйл ажиллагаанд тусгах нь багш бэлтгэдэг их сургуулиудын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд болон багшлах эрхийн шалгалтын агуулгыг боловсруулахад чухал хувь нэмэр болно гэж үзэж байна.

### **Судалгаанд дэвшүүлсэн асуудал:**

Өнгөрсөн зууны наяд оны үеэс багшийн ажил нь бие даасан мэргэжил мөн үү? Багш мэргэжилтэн гэж хэн бэ? Багш мэргэжилтэнг хэрхэн бэлтгэх вэ? Тэд ямар мэдлэг чадвар эзэмшсэн байх ёстой вэ? гэх мэт асуудлаар дэлхийн түвшинд олон тооны судалгааны хөтөлбөрүүд хэрэгжих болсон. Эдгээр хөтөлбөрт ирээдүйн багш хүний эзэмших ёстой мэдлэгийн цар хүрээг хэрхэн авч үзэж буйг харьцуулан судалж, түүний агуулгыг тоймлон гаргах зорилго тавьсан юм.

### **Судалгааны хүрээ ба арга зүй:**

Бид сурган хүмүүжүүлэх ухаан, мэргэжлийн дидактикийн суурь судалгааны салбарт хэрэгжсэн хэд хэдэн судалгааны хөтөлбөрийг сонгон авч, багш мэргэжилтний мэргэжлийн онцлогтой мэдлэгийн дор юуг ойлгож, түүнийг хэрхэн ангилан авч үзэж буй талаар судалж, мэдлэгийн төрөл бүрийн утга санааг нь тодруулахыг зорилоо. Багш мэргэжилтэн ямар мэдлэг, чадвартай байх талаар хийсэн суурь судалгааны дотор 1980 – аад оны сүүлээр Харвардын их сургуулийн Harvard Educational Review сэтгүүлд хэвлэгдсэн Стенфордын их сургуулийн багш эрдэмтэн Шулманы (Lee Shulmann) “Knowledge growth in teaching”, “Knowledge and teaching of the new reform” гэсэн өгүүлүүд зүй ёсоор ордог. Эрдэмтэн Шулман багшийн мэдлэгийг 3 бүлэгт ангилан авч үзэж,

t;uttj nau англи хэл дээр “*Content knowledge (CK)*, *pedagogical content knowledge (PCK)*, *pedagogical knowledge (PK)*” гэсэн нэр ухагдахуунаар илэрхийлсэн. Орчин үед багш мэргэжилтний талаар хийж буй бүхийл суурь судалгаануудад ерөнхийдөө энэхүү гурван төрлийн мэдлэгийг авч үзэж байна.

Бид европын холбооны эрдэмтдийн герман хэл дээр хэвлэгдсэн суурь судалгааны материалуудыг судалсан учир эхлээд нэр томъёо, түүний орчуулгын талаар зарим тайлбарыг хийх нь зүйтэй гэж үзлээ. МУИС-ийн МДССТ-ийн судлаачид эдгээр нэр томъёог монгол хэл дээр хөрвүүлэн хэрэглэж ирсэн уламжлалыг энд мөрдөв. Үүнд:

- **Content knowledge** – гэсэн ухагдахууны утга санааг герман хэл дээр Fachwissen-гэж илэрхийлдэг. Энэ ухагдахууныг тухайн шинжлэх ухаан мэдлэг буюу мэргэжлийн мэдлэг гэж монгол хэлэнд буулгасан. Энэ нь математикийн багш хүний хувьд бол математикийн шинжлэх ухааны мэдлэг гэсэн үг юм.
- **Pedagogical content knowledge**, германаар Fachdidaktisches Wissen гэсэн ухагдахууныг мэргэжлийн дидактикийн мэдлэг гэдэг. Энэ нь математикийн багш хүний хувьд бол математикийн хичээл, математикийг сурах ба сургах асуудлыг судалдаг математик дидактикийн шинжлэх ухааны мэдлэг юм.
- **pedagogical knowledge** – гэсэн ухагдахуун нь сурган хүмүүжүүлэх ухаан буюу сурган - сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэг ч гэж нэрлэдэг.

Багш мэргэжилтэнтэй холбоотой судалгаа, ном зүйд энэхүү гурван мэдлэгийг СК, PCK, PK гэж тэмдэглэж ямарч нэмэлт тайлбаргүйгээр хэрэглэж байгаа учир бид ч эдгээр тэмдэглэлийг хэрэглэх нь тохиромжтой гэж үзлээ. Сурган хүмүүжүүлэх ухаан ба мэргэжлийн дидактикийн шинжлэх ухааны суурь судалгааны түвшинд сүүлийн үед хэрэгжсэн хэд хэдэн судалгааны хөтөлбөрүүдийг сонгон, эдгээрт багш мэргэжилтэнд байх мэдлэг чадварыг хэрхэн бүтэцчилэн, агуулгыг нь тодорхойлж байгаа, ялангуяа мэргэжлийн дидактикийн мэдлэгийг ямар түвшинд авч үзэж байгааг тодруулахыг зорьсон юм.

### **COACTIV судалгаа.**

- Герман улсын Макс-Планкийн нэрэмжит боловсрол судлалын хүрээлэн өөрийн орны хэд хэдэн их сургуультай хамтран 2006-2009 онуудад багш мэргэжилтний мэргэжлийн цогц чадамжийн талаар COACTIV ( Professional Copetence of Teachers, Cognitive Activating Instruction, and the Development of Students' Mathematical Literacy) гэсэн сэдэвтэй судалгааны хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Судалгааны үзэл баримтлал нь багшлах боловсон хүчин тухайлбал математикийн багшийн мэргэжлийн цогц чадамж (professionelle Kompetenz) – танин мэдэхүйг идэвхжүүлдэг хичээл (kognitiv aktivierende Unterricht) – сурагчдын математикийн цогц чадамж (mathematische Kompetenz) гэсэн ухагдахуунуудын утга, эдгээрийн хоорондын уялдаа холбоон дээр төвлөрсөн байна. Судалгаа нь 2006 оноос хэд хэдэн үе шаттай хэрэгжиж, цаашид мөн үргэлжлэх юм байна. Судалгаанд тооцсон шинжлэх ухааны онол, арга зүй, мэдлэг эзэмшилтийг үнэлсэн загвар, тест, даалгаврууд, судалгааны эхний үр дүнг нарийвчлан тусгасан 400 орчим хуудастай ном хэвлэгдсэн байна. Үүнийг эрдэмтэд, багш нар ихээхэн сонирхож, эерэг үнэлгээ өгч байгаа вч байна. Тус судалгаанд Герман улсын

боловсрол судлалын хүрээлэнгүүд, их сургуулиудаас гадна АНУ, Англи, Израил, Тайван,Швецари, зэрэг орны эрдэмтэд тодорхой чиглэлүүдээр зөвлөлгөө өгч хамтран ажилласан байна. Энэ хүү судалгаанд багш мэргэжилтний загварыг гаргаж түүнийгээ математикийн багш мэргэжилтний хувьд нарийвчилсан бөгөөд судалгааны 1-р хэсгийн гол үр дүн нь аль ч мэргэжлийн багшийн мэдлэг, чадвар юу болох, түүнийг хэрхэн үнэлэх үйл ажиллагаанд онолын үзэл баримтлал болно гэж үзжээ.

### **Судалгаанд хөндөгдсөн зарим асуудлыг тодруулбал:**

- Багш хүн өөрийн мэргэжлээ удаан хугацааны туршид амжилттай хэрэгжүүлэхийн тулд хувь хүний хувьд тэрээр ямар урьдчилсан нөхцөлийг биелүүлсэн байх, өөрөөр хэлбэл тухайн хүнд ямар шинж чанар байх ёстой болохыг онол болон практикийн үүднээс талбарлах зорилго тавьсан. Багш хүний мэргэжлийн үйл ажиллагааны амжилт нь нэг талаас хичээл сургалтын бүхий л үйл ажиллагааны чанар үр өгөөж, сурагчдын сургалтын амжилт зэрэг сурч буй хүнтэй холбоотой үзүүлэлтээс хамаарахаас гадна нөгөө талаас тухайн хувь хүнд бие даан мэргэжил дээрээ өсөж өндийхийн тулд өөрт ноогдсон үүрэг даалгаврыг биелүүлэх, мэргэжилдээ сэтгэл хангалуун байж, урам зоригтой ажиллаж, мэргэжилдээ үнэнч байх зэргээр багш мэргэжилтэнд байвал зохих хувь хүний шинж чанарыг авч үзсэн.

**Зөвлөмж: Багш болох оюутныг сонгохдоо ч, багшлах эрх олгохдөр ч тухайн хүнд багш мэргэжилтэнд байх мэдлэг, чадварыг өөртөө шингээн авч чадах төрөлхийн шинж чанар (disposition )байгаа эсэхийг тандах үзүүлэлтүүдийг тусгах нь зүйтэй юм байна гэж үзлээ.**

- Дээрх судалгаанд дараа нь багш мэргэжилтэнд байх цогц чадамжийг тодорхойлсон. Ингэхдээ эхлээд ер нь “мэргэжилтэн” (Expert) гэж хэн бэ? гэдэг асуудлыг мэргэжилтний онол ба ба байгууллагын онолын үүднээс авч үзсэн. Энд тодруулсан онолын үзэл баримтлалыг багшийн ажил дээр буулган багшийн ажил нь мэргэжилтний хийх ажил мөн үү? Багшийн ажил хийж байгаа хүн багш мэргэжилтэн мөн үү? гэдгийг авч үзсэн. Ингээд багш мэргэжилтэн ямар байгууллагад, ямар үйлийг хийх вэ гэдгийг боловсролын онол болон байгууллагын онолын үүднээс авч үзсэн байна. Өөрөөр хэлбэл багш мэргэжилтэн гэж хэн бэ? гэдэг асуултын хариултыг олохын тулд дараах байдлаар хандсан. “Мэргэжилтэн”-д байх хамгийн чухал үзүүлэлт бол тэрээр тодорхой бүлэг хүмүүст үйлчлэх ёстой бөгөөд багш хүний хувьд энэ бүлэг хүмүүс буюу гол субъект сурагчид байх ёстой гэж үзээд багш болох хүнд байвал зохих мөн чанар, багш хүний ажиллах байгууллага, түүний онцлог зэрэг асуудлуудыг онолын түвшинд судалгааны олон арга зүйг хэрэглэн судалсан. Энд багшийн мэдлэгийг авч үзэхдээ дээд сургуульд сурч байх үед, багшийн ажилд сурч байх үед, багш мэргэжилтэн болж төлөвшиж байх үед гэж ангилан авч үзжээ. Математикийн багш мэргэжилтний хамгийн чухал мэдлэг нь мэргэжлийн дидактикийн мэдлэг (РСК) гэж үзсэн байна. Мэргэжлийн дидактикийн мэдлэг эзэмшсэнээр сурагчдын танин мэдэхүйг идэвхжүүлж, сурагч бүрд дэмжлэг үзүүлэхүйц хичээлийг явуулж чадах нөөц боломж багшид буй болно. Тодорхой мэргэжлийн мэдлэггүй мэргэжлийн дидактикийн мэдлэг байх боломжгүй. Иймд тодорхой мэргэжлийн мэдлэг (СК) бол мэргэжлийн дидактикийн мэдлэгтэй

байхын зайлшгүй урьдчилсан нөхцөл юм. Гэхдээ мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн дидактикийн мэдлэгийг орлож чадахгүй. Тухайлбал математик дидактикийн мэдлэг эзэмшихийн тулд математикийн мэдлэг зайлшгүй хэрэгтэй боловч математик дидактикийн мэдлэгийг орлож чадахгүй гэж үзсэн байна.

- Багш мэргэжилтний компетенц (Professional Competence of Teachers)-ийг тодорхойлох. Энд компетенц ухагдахууны хувьд боловсролын стандарттай адил “Definition and selection of **competencies** (DeSeCo): Theoretical and conceptual foundations. OECD, 2002” -ийн хүрээнд гарсан тодорхойлолтыг авсан байна.

Компетенц (**Competencies**) нь тодорхой асуудлыг шийдэх когнитив чадвар, дадал (хувь хүнд байж болох, сурч болох). Энэхүү чадвараа ямар ч нөхцөл байдалд амжилттай, хариуцлагатай ашиглаж чадах сэдэл тэмүүлэл бүхий социал чадвар ба бэлэн байдал. Компетенц нь чадвар, мэдлэг, ойлголт, үйл, туршлага, сэдэлтэй холбоотой санаануудыг өөртөө багтаадаг. Эдгээр санааг багш мэргэжилтний хувьд буулгавал багш хүн багш мэргэжилтэн эзэмших ёстой мэдлэгээ хэрэглэж дидактик шийдэл хийх чадвар гэж болох юм. Онолын түвшинд багш мэргэжилтний компетенцийг тодорхойлохдоо дараах санаануудыг тусгасан байна. Үүнд:

- Багшийн үндсэн ажил:
  - Хичээл явуулах, хийх
  - Хүнийг хүн болгон хүмүүжүүлэх
  - Хичээл, хүмүүжил хоёрыг хамтад нь авч үзэх.
- Багш мэргэжилтний мэдлэг
  - 3 төрлийн мэдлэг ,...үйлийн мэдлэг, ....
  - Сурагч- багшийн –харилцаа (ёс суртахуун, хариуцлага, үнэт зүйл, хувь хүний онцлог,..)
  - Танин мэдэхүйг идэвхижүүлдэг хичээл явуулах мэдлэг, чадвар , туршлага, сэдэл тэмүүлэл,

Судалгааны дараагийн хэсэг нь “**Танин мэдэхүйг идэвхижүүлдэг хичээл**” (**Cognitive Activating Instruction**)-ийн талаар авч үзсэн байна.

Багш мэргэжилтэн нь сурагчдын танин мэдэхүйг идэвхижүүлдэг хичээлийг явуулж чадсан нөхцөлд сурагчид нь мэдлэгээ хэрэглэж асуудал шийдвэрлэх чадвартай болно гэж үзээд энэ хичээлийн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Зорилго: хичээл дээр үзэж буй асуудлыг сурагчид цэвэрлэж биш харин үнэхээр ойлгож суралцах, сурч буй зүйл тухайн хүнд маш ойлгомжтой байж чадах хичээл.

Ойлгож сурах гэдгийн дор дараах санаанууд тусгагдсан байна:

- Хувь хүний бүтээлч, идэвхтэй мэдлэг **бүтээх үйл ажиллагаа**. Хувь хүний когнитив урьдчилсан нөхцөлөөс хамаарна. Мэдлэгийн бүтэц нь өөрчлөгдөж, цэглэгдэж, шинэчлэгдэх процесс. Мэдлэгийн хүрээ, зохион байгуулалт.
- Системтэй агуулгатай холбоотой боловч **контекст** , бодит байдал дээр хэрэгждэг.
- Сэдэл, тэмүүлэл, **метакогнитив** процессоор удирдагддаг.
- Сурах процессийг гярхай манаж, дэмжих. Буцах холбоос зайлшгүй. (diagnostic)

Сурах ба багшлах: Санал болгох- түүнийг үр ашигтай ашиглах хувь хүний идэвхи – загвар

- Хөгжих боломж хүүхэд бүрт бий

- Хөгжих орчинг нь бүрдүүлэх ёстой.

**Зөвлөмж:** Багш мэргэжилтний хувьд тухайн шинжлэх ухааны дидактикийн мэдлэг буюу мэргэжлийн дидактикийн мэдлэг нь хамгийн гол, чухал мэдлэг гэдэг дээр судлаачид нэгэн зэрэг хүлээн зөвшөөрч байна. Мэргэжлийн дидактикийн мэдлэг, чадвар нь айн (domain) онцлогтой. Судалгаанд багш мэргэжилтний мэдлэгийн талаар ерөнхий загвар боловсруулж улмаар математикийн багшийн жишээн дээр багш мэргэжилтний 3 мэдлэгийг нарийвчлан гаргасан байна. Иймд багшийн эрх олгох шалгалтын агуулгыг математикийн багшийн хувьд гаргахдаа эндээс баримжаа авах санаанууд байна гэж үзлээ.

### **MT21 –судалгаа.**

2006 оноос АНУ, Герман, Мексик, Өмнөт Солонгос, Тайван, Болгар 6 орон хамтран „Mathematics Teaching in the 21st Century (MT21)“-сэдэвт судалгааг хэрэгжүүлсэн. Судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн дунд ангид багшлах математикийн багшийг хэрхэн бэлтгэж буй байдалд анализ хийх, улмаар олон улсыг харьцуулан судлах боломжтой хэрэгслийг буй болгох, эндээс улс орон бүр жишиг авах боломжийн талаар авч үзсэн. Математик, байгалийн ухааны боловсролын чанарыг олон улсыг оролцуулан харьцуулан судалдаг TIMSS ба PISA хөтөлбөрүүдэд сурагчдын үзүүлдэг амжилтын ерөнхий тархалтыг эдгээр орнууд төлөөлж чадна гэж үзсэн. MT21–ийн судалгаа нь дараах үндсэн гол асуудлууд дээр төвлөрсөн:

- Дунд боловсролын түвшний математикийн багш болохоор бэлтгэгдэж байгаа оюутнуудын мэргэжлийн цогц чадамж нь ямар байна вэ?
- Математикийн багшийг бэлтгэж буй сургалтын нөхцөл байдлыг хэрхэн бүрдүүлсэн байна вэ?
- Математикийн багш болох мэргэжилтний мэргэжлийн цогц чадамж ба сургалтын орчны хооронд ямар хамаарал байна вэ?

Энэхүү судалгааны хөтөлбөр нь тодорхой асуудлууд дээр төвлөрсөн маш олон дэд төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Математикийн ба математик дидактикийн мэдлэгийн дор юуг ойлгохыг шийдэхдээ хоёр үзэл баримтлалд баримжаалсан утга санааг нь уялдуулан үзэж, баримжаалсан байна. Үүнд:

- Л. Шулманы санал болгосны дагуу когнитив түвшинд багш мэргэжилтний мэдлэгийг гурван төрөлд авч үзэх (СК, РСК, РК)
- А.Бромме зэрэг эрдэмтдийн санал болгосон мэргэжлийн дидактикийн мэдлэгийг (РСК) хамгийн чухал мэдлэг болгож, түүндээ математикийн мэдлэгээс гадна математикийн тухай мэдлэгийг тооцох улмаар математикийн хичээлийн хөтөлбөр, хичээл хийх, сурагчдын өмнөх төсөөллийн тухай мэдлэгүүдийг хооронд нь холбон авч үзэх.

Математик ба сурган хүмүүжүүлэх ухааны мэдлэгийн агуулга нь хөтөлбөрт оролцсон орнуудын хувьд ерөнхий төстэй байсан бөгөөд харин математик дидактикийн мэдлэгийн агуулга, арга зүй нь нэлээн ялгаатай байсан байна. Мэргэжлийн дидактикийн мэдлэгийг үнэлсэн судалгааны үр дүнд тулгуурлан судалгаанд хамрагдсан оюутнуудыг мэргэжлийн дидактикийн мэдлэгээр гурван түвшинд ангилсан байна.

Үүнд:

- „anwendungsbezogene Typ“: Энэ хэсэгт хамрагдаж буй оюутнууд нь хичээл дээр загварчлах үйлийг сайн хийж, энд байгаа дидактикийг зохих түвшинд эзэмшсэн байсан. Математик загварчлалыг хийхэд хэрэглэгдэх математик мэдлэг нь хангалттай байгааг харуулсан.
- “formale Typ” : Энэ хэсэгт хамрагдаж буй оюутнууд нь хичээл дээр загварчлах үйл хийх мэдлэг нь тааруу, ийм үйл ажиллагаа явуулахаас татгалзаж байгаа нь харагдсан. Харин математик загварын тухай математикийн мэдлэг нь сайн байсан.
- „Mischtypen“: Энэ хэсэгт хамрагдаж буй оюутнуудын мэдлэгийн когнитив элементийг хүрэлцээтэй эзэмшсэн боловч математик дидактикийн мэдлэг чадвар нь тааруу байсан. Энэ нь математикийн багшийг бэлтгэх хөтөлбөрт математик дидактикийн хичээлүүд бага ордогтой холбоотой гэж үзсэн байна.

### **ProwiN (Professional Knowledge of Science Teachers) -судалгаа.**

Герман улсын боловсрол шинжлэх ухааны холбооны яамны дэмжлэгтэйгээр “ Байгалийн ухааны багшийн мэргэжлийн мэдлэг” сэдэвт хөтөлбөр 2011 оноос эхлэн хэрэгжсэн байна. Энэхүү судалгаа нь эхний ээлжинд багш мэргэжилтний мэдлэгийг илэрхийлэхэд хамгийн чухал гэж үзэж байгаа дээр дурдсан гурван төрлийн мэдлэгийн талаар гарсан судалгааны материалуудад анализ хийж, судалгааны орчин цагийн түвшинг тогтоосон байна. Судалгаанууд ерөнхийдөө математикийн багшийн жишээн дээр хийгдсэнийг онцлон багш мэргэжилтний гурван төрлийн мэдлэгийг ерөнхийгөөс тодорхойд нарийвчлан буулгах судалгаа одоогоор зөвхөн математикийн багш мэргэжил дээр төвлөрч байгааг дурдсан

Судалгаанд дэвшүүлсэн гол асуудал нь багш нарын мэргэжлийн мэдлэг. Энэхүү мэдлэг нь хичээл сургалтын ажилд ямар нөлөө үзүүлж байгааг илэрхийлэх загварыг бүтээж, үүнийг анх удаа байгалийн ухааны (физик, хими, биологи) багшийн хувьд авч үзэж буйг онцолсон байна. Байгалийн ухааны энэхүү гурван хичээлийн үйл явц нь харилцан адилгүй ч гэсэн туршилт ба загварыг хэрэглэх ерөнхий зарчим нь ижил байдаг.

Мэргэжлийн мэдлэг ба мэргэжлийн дидактикийн мэдлэг нь айн онцлогтойг дурдаад, аль алинд нь декларатив ба процедурал мэдлэгээр илэрхийлсэн . Үнэлгээнд мэргэжлийн дидактикийн мэдлэгийн хувьд туршилт, загвар ба үзэл баримтлал, сурагчдын өмнөх төсөөллийг, сурган хүмүүжүүлэх мэдлэгт анги удирдах, хичээлийн аргууд, хувь хүний сурах процесс, сургалтын амжилтын үнэлгээг авсан байна. Энэхүү судалгааны хамгийн чухал асуудал нь мэдлэгийг үнэлэх даалгавар, тестийг боловсруулсан арга зүй юм.

### **Манай оронд хийсэн судалгаанаас .**

Манай орны боловсрол судлалын салбарын үе үеийн эрдэмтэд, багш мэргэжилтэнг хэрхэн бэлтгэх, тэдэнд ямар мэдлэг чадвар эзэмшүүлэх чиглэлээр олон тооны судалгаа хийж ирсэнээс заримыг дурдая. МУИС, МУБИС-ийн багш нарын хамтран БСШУЯ, ЮНЕСКО –ийн бүсийн төвийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бүтээгдсэн багшийн загварт мөн дээр дурьдсан гурван төрлийн мэдлэгт баримжаалан багшийн цогц чадамжуудыг илэрхийлсэн



Ном зүй:

1. Shulman, L. (1986). Those who understand: Knowledge growth in teaching. *Educational Researcher*, 15 (2), 4–14.
2. Shulman, L. S. (1987). Knowledge and teaching of the new reform. *Harvard Educational Review*, 57, 1–22.
3. Krauss, S., Brunner, M., Kunter, M., Baumert, J., Blum, W., Neubrand, M. et al. (2008). Pedagogical content knowledge and content knowledge of secondary mathematics teachers. *Journal of Educational Psychology*, 100 (3), 716–725.
4. Krauss, S., Blum, W., Brunner, M., Neubrand, M., Baumert, J., Kunter, M. et al. (2011). Konzeptualisierung und Testkonstruktion zum fachbezogenen Professionswissen von Mathematiklehrkräften. In M. Kunter, J. Baumert, W. Blum, U. Klusmann, S. Krauss & M. Neubrand (Hrsg.), *Professionelle Kompetenz von Lehrkräften. Ergebnisse des forschungsprogramms COACTIV* (S. 135–161). Münster: Waxmann.
5. <http://tedsm.hu-berlin.de/publik/index.html>
6. Tepner, O., Borowski, A., und andere. Item Development Model for Assessing Professional Knowledge of Science Teachers. *Zeitschrift für Didaktik der Naturwissenschaften*; Jg. 18, 2012
7. Bromme, R. (1995). What Exactly is 'Pedagogical Content Knowledge'? –Critical Remarks Regarding a Fruitful Research Program. In Hopmann, S. & Riquarts, K. (Hrsg.): *Didaktik and/or Curriculum*. IPN Schriftenreihe 147 Kiel: IPN
8. Ц.Лувсандорж.(2003) XXI зууны багшийн боловсрол, түүний хөгжлийн чиг хандлага, Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага . х.30-36.
9. Ч.Лхагважав., Н.Нэргүй., Багш боловсролын стандарт, кинрикулимийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал. Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага .х.5-29.

## **Судалгаа 2: Багшийн эрх олгох шалгалт эрх зүйн орчинг бүрдүүлэх, шалгалтын бүтэц, агуулгатай холбоотой асуудлуудаар гадаад орнуудын туршлага судлах. Шаардлагатай бичиг баримтуудыг орчуулах.**

Бусад орнуудад багшлах эрхийг хэрхэн ойлгодог талаар бид харьцуулсан судалгаа хийж үр дүнг нь хүснэгтээр харуулав. Тухайн улс орны боловсролын системийн хөгжил, онцлогтой уялдан сонгон авсан үзүүлэлт нь харилцан адилгүй байна. Эдгээр материалууд нь багшлах эрхийн шалгалтын агуулга, арга зүйг боловсруулах хүмүүст нэмэлт мэдээлэл болно гэж үзлээ.

Эндээс өөрийн орны онцлогийг тооцон зарим санааг тусгах боломжтой юм. Энэ үүднээс ажлын хэсгээс боловсруулсан нэгэн хувилбарыг санал болгож байна.

Хэд хэдэн орны багшийн стандартыг харьцуулан судалж ерөнхий хүрээ, агуулгыг

## БАГШЛАХ ЭРХИЙН ШАЛГАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Улс орон	Шалгалтын төрөл хэлбэр	Агуулга	Хэзээ өгөх
АНУ	<p>Praxis<sup>1</sup> – I буюу <i>Академик чадварын шалгалт</i></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Хэддүгээр ангид, ямар хичээл заахаас үл хамааран бүх багшид хэрэгтэй унших, бичих болон математик чадварыг үнэлэх шалгалт юм.</li> <li>▪ Энэхүү шалгалтыг уламжлалт (цаас, харандаатай) хэлбэрээр болон компьютерийн программын тусламжтай өгч болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Асуудлын мөн чанар, учир шалтгааныг ухамсарлан ойлгож унших чадварыг сорих 56 асуулт бүхий даалгаврыг 85 минут гүйцэтгэнэ.</li> <li>▪ Бүтээлчээр сэтгэн бодож, дүгнэлт гарган бичих чадварыг сорих 40 асуултад богино хариулт бичгээр өгч, хоёр эсээ бичнэ. Нийтдээ 60 минутанд гүйцэтгэнэ.</li> <li>▪ Тоон ба хэмжихүйн ухааны мэдлэгээ ашиглан хүрээлэн буй орчин, нийгэм соёлдоо гарч буй ямар нэг өөрчлөлтийн мөн чанар, зүй тогтлыг ухаарч ойлгох, өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэглэгдэх нарийн тооцоо хийж чадах эсэхийг сорих 56 асуулт бүхий даалгаврыг 85 минутанд гүйцэтгэнэ.</li> </ul>	<p>Багш бэлтгэх сургуульд суралцаж байх хугацаандаа уг шалгалтыг өгсөн байна.</p>
	<p>Praxis – II <i>Багш боловсролын болон заах хичээлийн мэдлэгийн</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Заах хичээлийн онолын мэдлэгийн шалгалт</li> <li>▪ Сурган хүмүүжүүлэх ухаан, боловсролын сэтгэл судлалын мэдлэг, чадварын шалгалт</li> <li>▪ Мэргэжлийн дидактик (content pedagogy)-ийн мэдлэг чадварын</li> </ul>	<p>Багш бэлтгэх сургуулийг төгссөний дараа өгнө.</p>

<sup>1</sup>Багшлах чадварын шалгалт

	<i>шалгалт</i>	шалгалт Дээрх гурван хүрээнд олон хариултаас зөвийг сонгох тест бөглөн, бүлэг бүрийн төгсгөлд гурваас дөрвөн кейсийг шинжилж, кейс бүр дээр гурван богино асуултанд хариулт бичих даалгаврыг гүйцэтгэнэ.	
	Praxis – III <i>Багшлахуйн (анги танхим дахь үйл ажиллагааны) гүйцэтгэлийн үнэлгээ.</i>  <i>Энэ нь гүйцэтгэлд суурилсан үнэлгээний тогтолцоо болохоос шалгалт биш юм.</i>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Шинэ багшийн багшлах чадварыг үнэлэхэд чиглэх бөгөөд дараах зүйлд төвлөрнө: <ul style="list-style-type: none"> <li>○ Сургалтын төлөвлөлт (сургалтын хөтөлбөр боловсруулах, ээлжит хичээлийн төлөвлөлт г.м)</li> <li>○ Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт</li> <li>○ Анги танхимын менежмент</li> <li>○ Сурагчийн ахиц дэвшлийн үнэлгээ</li> <li>○ Сургалтын үр дүн</li> </ul> </li> <li>▪ Багш суралцагчийн хөгжлийн түвшин ба соёлын ялгаатай байдалд хэр мэдрэмжтэй хандаж байгааг үнэлнэ.</li> <li>▪ Анги танхимд хийх ажиглалт, уг ажиглалтын өмнө ба дараа үндэсний болон орон нутгийн түвшинд бэлтгэгдсэн мэргэжилтэн/судлаачтай хийх ярилцлага нь Praxis-III-ийн үндсэн хэсэг юм.</li> <li>▪ Ажиглалтын материалд (ажиглалтын тэмдэглэл, үнэлгээний хуудас) ээлжит хичээлийн төлөвлөгөө гэх мэтийн ажлын дээжээс нэмж хавсаргана.</li> </ul>	Нэг жилийн хугацаатай багшилсны дараа уг үнэлгээг хийх бөгөөд амжилттай болсон тохиолдолд муж улсын боловсролын байгууллагаас багшлах эрхийн лиценз олгох шийдвэр гарна.
	<i>Бүртгэл</i>	Орон нутгийн боловсролын төв (16 төв байгаа)-д бүртгүүлж, өргөдөл	Багш бэлтгэх сургууль төгссөний

БНСУ		өгнө.	дараа (58706 шинэ төгсөгч өргөдөл өгсөн байв)
	<i>Тест</i>	Суралцахуй, багшлахуй, боловсролын эрх зүйн мэдлэгийг сорих шалгалт	Орон нутгийн боловсролын төв өргөдлийг хүлээн авсны дараа
	<i>Эсээ</i>	Багшийн ёс зүй, үнэт зүйл, хандлагыг үнэлэх бичгийн шалгалт	Тестэнд тэнцсэн нөхцөлд
	<i>Гүнзгийрүүлсэн ярилцлага ба ур чадварын шалгалт</i>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хичээл зааж үзүүлэх</li> <li>▪ Ярилцлага өгөх</li> </ul>	Эсээ бичлэгийн шалгалтаа амжилттай өгсөн нөхцөлд  (Дээрх өргөдөл гаргагчдаас 2525 багш дунд сургуульд ажиллах эрхээ авсан байв)

Багшлах эрхийн шалгалтын хувилбар

(Ажлын хэсгээс оруулж буй санал)

Үе шат	Шалгалтын төрөл хэлбэр	Агуулга	Хугацаа
I	<p><i>Багш мэргэжлийн мэдлэг, чадварын шалгалт</i></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Стандартчилсан тест</li> <li>▪ Бичгийн шалгалт <ul style="list-style-type: none"> <li>○ 100-150 үгтэй</li> </ul> </li> </ul>	<ol style="list-style-type: none"> <li>1. <i>Заах хичээлийн онолын мэдлэгийг шалгах тест</i> (25-30 даалгаварыг 60 минутанд гүйцэтгэнэ)</li> <li>2. <i>А/СХУ, боловсролын сэтгэл судлалын мэдлэг шалгах тест</i> <ul style="list-style-type: none"> <li>▪ Суралцагчийн хөгжил ба суралцахуй (25%)</li> <li>▪ Багш, багшийн үйл ажиллагааба хөгжил (25%)</li> </ul> </li> </ol>	Багш бэлтгэх сургууль төгссөний дараа

	<p>товчхон хариулт</p> <ul style="list-style-type: none"> <li>○ 300-600 үгтэй дэлгэрэнгүй хариулт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Сургалт, үнэлгээ, суралцах орчин (30%)</li> <li>▪ Сургууль, боловсролын бодлого, эрх зүй (20%)</li> </ul> <p><i>Б/ Багшийнасуудал шийдвэрлэх чадварыг үнэлэх асуулт даалгавар</i></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Өгөгдсөн кейст анализ хийнэ.</li> <li>▪ Өгсөн асуултад товч (100-150 үгэнд) хариулна.</li> </ul> <p><i>В/ Багшийн үнэт зүйл, итгэл үнэмшил, эерэг хандлагыг үнэлэх асуулт даалгавар</i></p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Асуулт даалгаврын тавил буюу нөхцөлд анализ хийнэ.</li> <li>▪ Өөрийн байр суурийг илэрхийлсэн дэлгэрэнгүй (300-600 үгтэй) хариулт бичнэ.</li> </ul> <p>3. Мэргэжлийн дидактикийн мэдлэг, чадвар</p>	
--	--	--	--

Нэг дэх шатны шалгалтыг амжилттай өгсөн тохиолдолд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт дадлагажигч багшаар ажиллах эрх нээгдэнэ. Уг эрхийг шалгалтын комиссын үнэлгээний дүнд тулгуурлан аймаг, дүүргийн боловсролын газраас олгоно. Сургуулийн захиргаа ажилд сонгон шалгаруулж авч буй шинэ багштай ярилцлага хийж, хичээл заалгаж үзэж болно. Ярилцлага болон хичээлийн ажиглалтад тулгуурлан тухайн дадлагажигч багшид мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллах зөвлөх багшийг томилж ажиллуулна. Зөвлөх багшаар ажиллуулах тухай захирлын тушаал гаргана. Дадлагажигч багш өөрийгөө хөгжүүлэх хувийн ажлын төлөвлөгөө гарган ажиллана.

<p>II</p>	<p>Багшлахуйн гүйцэтгэлийн үнэлгээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Багшийн өөрийн үнэлгээний тайлан</li> <li>▪ Анги танхимд хийх ажиглалт</li> <li>▪ Ярилцлага</li> <li>▪ Багшийн бүтээлийн сан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Шинэ багшийн багшлах чадварыг үнэлэхдээ дараах баримтыг ашиглана: <ul style="list-style-type: none"> <li>○ Нэгж хичээлийн хөтөлбөр, ээлжит хичээлийн төлөвлөгөө, тэдгээрт хийсэн эргэцүүлэл (эдгээрийг багшийн бүтээлийн санд хийсэн байна)</li> <li>○ Анги, сурагчдын хамт олон, эцэг эхтэй ажиллах төлөвлөгөө, төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт</li> <li>○ Сурагчдын суралцах-танин</li> </ul> </li> </ul>	<p>Дадлагажигч багшаар нэг жил ажилласны дараа гүйцэтгэлийн үнэлгээг хийнэ. Амжилттай дүн үзүүлсэн тохиолдолд багшлах эрхийн үнэмлэхийг</p>
-----------	--	---	---

		<p>мэдэх үйл ажиллагааг хөтлөх, чиглүүлэх, зохион байгуулах чадвар</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Сурагчийн ахиц дэвшлийг үнэлж, дүн шинжилгээ хийсэн байдал</li> <li>○ Сургалтын болон хичээлээс гадуурх ажлын үр дүн, оролцогчдын сэтгэл ханамж</li> <li>○ Багш, хүүхэд бүрийн хөгжлийн түвшин ба ялгаатай байдлыг мэдрэх, ойлгох чадвар</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>▪ Багшийн өөрийгөө хөгжүүлсэн, мэргэжлийн хамт олон, эцэг эхтэй хамтарч ажилласан байдлыг үнэлэхдээ тухайн багштай болон сургуулийн удирдлага, заах аргын нэгдлийн ахлагч, зөвлөх багшаар ажилласан багштай хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагын материалыг баримт болгон ашиглана.</li> </ul>	<p>олгоно.</p>
--	--	---	----------------

Улс орнуудын шинэ багшийн стандартын харьцуулалт

Хүснэгт 1.

Стандартын тухай мэдээлэл	УЛС ОРОН						
	АНУ	Англи	Шотланд	Сингапур	ХБНГУ	ОХУ	БНХАУ
Багшийн стандартыг боловсруулж хэрэглэсэн хугацаа	1992 оноос. 2011 онд шинэчлэн боловсруулсан	2001 оноос. 2007 онд шинэчилсэн.	2000 оноос	2001 оноос	2004 оноос	2010 оноос	2007 оноос
Стандартын зориулалт, хэрэглээ	In TASC буюу Багшийг үнэлэх ба тэдэнд дэмжлэг үзүүлэх муж дундын консорциумаас гаргасан Багшийн загвар стандартад үндэслэн муж улс бүр шинэ багшид багшлах эрх (лиценз) олгох стандартыг боловсруулан мөрддөг. Энэхүү шинэ багшийн	Багш бэлтгэх сургууль төгсөгч нь Англи, Уэйлсийн “Багшийн ерөнхий зөвлөл” ( <a href="http://www.gtce.org.uk">www.gtce.org.uk</a> ) –д бүртгүүлж, “мэргэжлийн багш” статустай болно. Үүний тулд шинэ багшийн стандартыг хангах шаардлагатай. Энэхүү шинэ багшийн стандарт нь үндсэн, ахисан	Багш бэлтгэх сургууль төгсөгч бүр Шотландын багшийн ерөнхий зөвлөл ( <a href="http://www.gtcs.org.uk">www.gtcs.org.uk</a> ) –д бүртгүүлж, багшийн стандартыг хангах шаардлагатай. Багш бэлтгэх сургуулиудын багш боловсролын хөтөлбөрүүд нь уг стандартыг хангах ёстой бөгөөд төгсөгч багш бүртгэлийн	Багш бэлтгэх сургууль төгсөгч нь Сингапурын боловсролын яам ( <a href="http://www.moe.gov.sg">www.moe.gov.sg</a> ) -наас зохион байгуулдаг үндэсний хэмжээний бүртгэлд бүртгүүлж, багшлах эрхийн гэрчилгээ авна. Үүний тулд тус яамнаас гаргасан чадамжид суурилсан шаардлагуудыг хангах ёстой. Эдгээр	Муж бүр шинэ багшийн стандарттай байх ба эдгээр нь сургууль, боловсролын чанарыг сайжруулах, хөгжүүлэх үндэс нь болдог.	Багш боловсролын тогтолцоог агуулгаар нь өөрчлөхийн тулд орчин үеийн багш нарыг чанарын хувьд өөр агуулга хэлбэрээр боловсролын сэтгэл зүйч чиглэлээр бэлтгэхэд туслах зориулалттай. Багш бэлтгэх	Багшийн стандарт нь багшийн мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадвар, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд сургууль, боловсролын байгууллагаас хяналт тавих зориулалттай.

	стандартыг багш бэлтгэх сургуулийн багш боловсролын хөтөлбөрийн хүрээ, агуулгыг тодорхойлоход ашигладаг.	түвшний, тэргүүлэх, өндөр зэрэглэлийн багш нарын стандартыг боловсруулах суурь болдог.	явцад үнэлүүлэх мэдлэг, чадвар, хандлагад суурилсан байна. Энэхүү стандартыг багш бэлтгэх сургууль төгсөгчдийн судлах багш боловсролын хичээлүүдийн хөтөлбөрийг боловсруулахад ашиглана.	шаардлага нь багшийн стандартын үүргийг гүйцэтгэж байна.		сургуулийн бакалавр, магистрийн түвшний сэтгэл судлал – сурган хүмүүжүүлэх боловсролын агуулгыг шинэчлэхэд зориулагдсан.	
Стандартын үүрэг	<b>АНУ</b> Багшийн стандарт нь гурван үндсэн үүргийг гүйцэтгэж байна: 1.Багшлахуйн	<b>Англи</b> Багшийн стандарт нь дараах үүргийг гүйцэтгэнэ: 1.Багш мэргэжлийн шаардлагыг	<b>Шотланд</b> -Багшийн анхан шатны боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулах бенчмарк/жишиг үзүүлэлт болох	<b>Сингапур</b> Багш болох гэж буй, багшийн ажлыг эхлэн хийж буй хүмүүс өөрсдийгөө мэргэжлийн хувьд хөгжүүлэх,	<b>ХБНГУ</b> -Сургалт, боловсролын чанарыг сайжруулах үндсэн хэрэглүүр болох	<b>ОХУ</b> Багш мэргэжлийн боловсролын тогтолцооны агуулгыг шинэчлэх хэрэглүүр	<b>БНХАУ</b> Багшийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын хариуцлагад хяналт тавих



	хөгжлийн хэтийн чиг хандлага/ алсын харааны хүрээг тогтоох 2.Заавал хангах ёстой гүйцэтгэлийн түвшинг тодорхойлох 3.Багш мэргэжил дээрээ суралцаж, хөгжих боломжийг илэрхийлэх	хангаж байгааг, багшид ямар ахиц дэвшил гарч байгааг тодорхойлох 2.Багш мэргэжлийн онцлог шинжийг тодорхой болгох 3.Багшид мэргэжил дээрээ хөгжих хэрэгцээг тодорхойлоход туслах 4.Багш мэргэжлийнхээ тухайн түвшинд юуг хийж гүйцэтгэхийг тодорхойлох	-Багш бэлтгэх сургууль төгсөгчийн сурлагын амжилтыг илтгэх, тайлагнах хүрээг тогтоох -Багш мэргэжил дээрээ тасралтгүй хөгжих чиглэлийг илэрхийлэх	чадавхижуулахад туслах хэрэглэгдэхүүн болох	-Багш нарын заавал мөрдөх шаардлагатай дүрэм журам байх	болох	хэрэгсэл болох
Стандартыг боловсруулахад тулгуурласан “Багш”-ийн загвар	<b>АНУ</b> - Үр дүнтэй багш - Эргэцүүлэгч - Шинэчлэгч/ Манлайлагч	<b>Англи</b> - Үр дүнтэй багш - Эргэцүүлэгч	<b>Шотланд</b> - Үр дүнтэй багш - Эргэцүүлэгч - Шинжлэн судлаач	<b>Сингапур</b> - Үр дүнтэй багш - Багш мэргэжилт-ний үнэт зүйлст суурилсан загвар (V <sup>3</sup> SK model)	<b>ХБНГУ</b> - Үр дүнтэй багш	<b>ОХУ</b> Судлаг-дахуунд тулгуурласан	<b>БНХАУ</b> - Үр дүнтэй багш - Шинэч-лэгч багш
Стандартыг	<b>АНУ</b>	<b>Англи</b>	<b>Шотланд</b>	<b>Сингапур</b>	<b>ХБНГУ</b>	<b>ОХУ</b>	<b>БНХАУ</b>

боловсруулсан хүмүүс, байгууллага	Багш боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл, Боловсролын үндэсний зөвлөл, Америкийн багш боловсролын коллежуудын холбоо, Америкийн багш нарын холбоо зэрэг 20 орчим байгууллагын төлөөлөл бүхий мэргэжилтнүүдийн баг.	Англи, Уэйлсийн Багшийн ерөнхий зөвлөл гол үүрэг гүйцэтгэсэн.	Багшийн анхан шатны боловсролын чанарын баталгаа хариуцсан байнгын комиссын гишүүд, их, дээд сургууль, дунд сургууль, багш нарын мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг.	Багш нар, шинжээчид, боловсролын яамны ажилтнууд оролцсон баг гүйцэтгэсэн. Сингапурын боловсролын үндэсний хүрээлэнгээс багш бэлтгэх хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн үнэлгээний тайлан, зөвлөмжийг ашигласан.	Муж улсуудын Соёлын сайд нарын байнгын бага хурлын нарийн бичгийн дарга нарын газрын хуралдаанаар хэлэлцэж баталсан. Муж бүр өөрийн стандартыг боловсруулдаг.	ОХУ-ын мэргэжлийн дээд боловсролын стандартын “Сэтгэл зүй-сурган хүмүүжүүлэх боловсрол” төслийн баг.	Бүх үндэстний боловсролын стандартын товчоо гол үүрэг гүйцэтгэсэн.
Багшийн стандартын агуулгын хүрээ	<b>АНУ</b> Шинэ багшийн стандарт нь дараах дөрвөн үндсэн хэсэг бүхий 10 стандартаас бүрдэх бөгөөд стандарт тус бүр нь багшийн	<b>Англи</b> Шинэ багшийн стандарт нь дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. <u>1.Мэргэжилтэн бие хүний шинж, хандлага</u> -Хүүхэдтэй	<b>Шотланд</b> Багш бэлтгэх сургууль төгсөгчид болон багш боловсролын хөтөлбөрүүд нь дараах гурван үндсэн хэсэг бүхий	<b>Сингапур</b> Багш мэргэжлээр төгсөгчид болон шинэ багш нарын эзэмшвэл зохих чадамжийн бүтэцчилсэн хүрээг дараах байдлаар тодорхойлсон	<b>ХБНГУ</b> Багш бэлтгэх сургууль төгсөгч, шинэ багшийн стандарт нь дараах дөрвөн үндсэн хэсгээс	<b>ОХУ</b> Төгсөгчийн эзэмшвэл зохих чадамжид тавих шаардлагыг дараах хоёр хүрээнд тодорхойл-	<b>БНХАУ</b> Багшийн стандарт нь дараах таван үндсэн хэсгээс бүрдэнэ. <u>1.Суралцаа-ийг цогц</u>

	<p>гүйцэтгэл буюу ур чадвар, мэргэжлийн мэдлэг, хандлагад тавигдах шаардлагуудыг агуулна.</p> <p><u>А. Суралцагч ба суралцахуй</u></p> <p>1.Суралцагчийн хөгжил</p> <p>2.Суралцахуйн ялгаатай байдал</p> <p>3.Суралцах орчин</p> <p><u>Б.Агуулга</u></p> <p>4.Агуулгын мэдлэг</p> <p>5.Агуулгын хэрэглээ</p> <p><u>В. Сургалтын арга зүй</u></p> <p>6.Үнэлгээ</p> <p>7.Сургалтын төлөвлөлт</p> <p>8.Сургалтын арга</p> <p><u>Г. Мэргэжлийн хариуцлага</u></p> <p>9.Мэргэжил</p>	<p>харилцаа тогтоох хүрээнд</p> <p>–Ажил үүргийн хүрээнд</p> <p>-Бусадтай харилцах, хамтран ажиллах хүрээнд</p> <p>-Мэргэжил дээрээ хөгжих хүрээнд ямар эерэг чанар, хандлага төлөвшсөн байхыг шаардсан</p> <p><u>2.Мэргэжлийн ойлголт, мэдлэг</u></p> <p>-Суралцахуй ба багшлахуй</p> <p>-Үнэлгээ ба хяналт шинжилгээ</p> <p>-Сургалтын хөтөлбөр</p> <p>-МХТехнологи</p> <p>-Суралцагчийн өвөрмөц онцлог, сайн сайхан байдал</p> <p><u>3.Мэргэжлийн үр чадвар</u></p>	<p>стандартыг хангах ёстой.</p> <p><u>1.Мэргэжлийн мэдлэг, ойлголт</u></p> <p>-Сургалтын хөтөлбөр</p> <p>-Бичиг үсгийн боловсрол</p> <p>-Мэргэжлийн үнэт зүйл, практик үйл ажиллагааг тайлбарлах онол, үзэл санаа, зарчим</p> <p>-Боловсролын тогтолцоо, бодлого, зарчим</p> <p>-Багш мэргэжлийн ажил үүргийн тухай мэдлэг</p> <p>-Боловсролын судалгаа, түүний хувь нэмэр</p> <p><u>2.Мэргэжлийн үр чадвар</u></p> <p>-Анги танхимд суралцагчидтай харилцах</p> <p>-Анги танхимын зохион</p>	<p>байна. Үүнд:</p> <p><u>1."Багш" мэргэжилтний үнэт зүйлс</u></p> <p>-Бүх хүүхэд сурч чадна гэдэгт итгэх</p> <p>-Бүх хүүхдэд халамж анхаарал тавих</p> <p>-Хувь суралцагчийн өвөрмөц ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах</p> <p>-Мэргэжилдээ үнэнч байх, багшийн ажилдаа өөрийгөө зориулахад бэлэн</p> <p>-Хамтын үйл ажиллагаа, хамтын хариуцлагыг эрхэмлэх</p> <p>-Тасралтгүй суралцах хүсэл эрмэлзэл, шилдэг нь байх</p>	<p>бүрдэх 11 чадамжид тавигдах онолын ба практик үйл ажиллагааны стандартаас бүрдэнэ.</p> <p>Үүнд:</p> <p><u>А. Хичээл заах</u></p> <p>1.Хичээлээ төлөвлөж, зохион байгуулах</p> <p>2.Сурах орчин нөхцөл бүрдүүлэх</p> <p>3.Суралцагчдыг бие даан суралцах чадварт сургах</p> <p><u>Б.Хүмүүжүүлэх</u></p> <p>4.Сурагчдын амьдралын нийгэм соёлын нөхцлийг мэдэж, хөгжил</p>	<p>сон байна.</p> <p><u>1.Ерөнхий соёлын чадамж</u></p> <p>-Нийгэм соёлын хөгжлийн үндсэн зүй тогтлыг мэддэг байх</p> <p>-Ёс суртахууны хэм хэмжээ зан харилцааны соёл</p> <p>-Орос хэлний аман ба бичгийн чадвар, утга зохиолын хэл эзэмшсэн байх</p> <p>-Шинжлэх ухааны сэдэв дээр ажиллах чадвар</p> <p>-Гадаад хэлний мэдлэг</p>	<p><u>хөгжүүлэх</u></p> <p>-Суралцагчийн хувийн онцлогийг илрүүлж, авьяас чадварыг хөгжүүлэх</p> <p>-Сурах үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, саад, алдаа, буруу зуршлыг судлан илрүүлэх</p> <p><u>2.Багшийн мэргэжлийн мэдлэг, үр чадвар, сургалтын арга зүй, хэрэглүүр</u></p> <p>-Мэдлэгийг чадвар болгон төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулах</p>
--	---	--	---	---	---	--	---

	<p>дээрээ суралцахуй ба ёс зүй 10.Манлайлал ба хамтын ажиллагаа</p>	<p>-Төлөвлөх -Хичээл заах -Үнэлэх, хяналт-шинжилгээ хийх, зөвлөх -Багшлах үйл ажиллагааны эргэцүүлэл хийх -Суралцах орчин бүрдүүлэх -Багаар хамтарч ажиллах</p>	<p>байгуулалт, менежмент -Үнэлэх -Мэргэжлийн эргэцүүлэл хийх, мэргэжил нэгтний хүрээнд хамтарч ажиллах <u>3.Мэргэжлийн үнэт зүйл, амлалт</u> -Нийгмийн шударга ёс -Мэргэжил дээрээ суралцаж, хөгжих -Ажиллаж буй орчин тойрны хүмүүсээ үнэлэх, хүндэтгэх</p>	<p>тэмүүлэл, шинэчлэлийг дэмжих 2. <u>“Багш” мэргэжилтний үр чадвар</u> -Сурган хүмүүжүүлэх/мэдлэг бүтээх үйл явцыг хөтлөх -Харилцах -Эргэцүүлэх -Хувь хүний (зохицох, цагийн менежмент) -Удирдахуйн болон менежментийн 3.<u>Багш мэргэжилтний мэдлэг</u> -Суралцагсад, тэдний нийгмийн хам хүрээ/контекст дэх хөгжил -Заах хичээл, сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн материал -Багшлахуй</p>	<p>төлөвшилд нь нөлөөлөх 5.Хэм хэмжээ, үнэт зүйлсийг эзэмшүүлж, өөрийн үнэлгээг дэмжих 6.Үүссэн асуудал, зөрчлийг шийдвэрлэх В. <u>Үнэлгээ</u> 7.Үнэлгээг шударга, хариуцлагатай хийх 8.Үнэлгээний тунгалаг аргуудыг хэрэглэх Г. <u>Шинэчлэл</u> 9.Мэргэжлийн хариуцлага, үүргээ ухамсарлах 10.Тасралтгүй суралцах 11.Сургуулиа хөгжүүлэх төсөл хөтөлбөр</p>	<p>-Мэдээллийн технологийг ашиглах -Шинжлэх ухааны судалгаа явуулах зарчмыг ойлгосон, шинжлэх ухааны мэдлэг эзэмших арга барилтай -Бие бялдар, эрүүл мэндийн бэлтгэлтэй г.м. 2. <u>Мэргэжлийн чадамж</u> -Хүүхдийн сэтгэц, физиологи, сэтгэл зүйн үндсэн зүй тогтлыг мэддэг байх -Онош зүйн арга барилтай</p>	<p>3.<u>Үнэлж дүгнэх хариуцлага</u> -Жишиг даалгавар боловсруулах -Зөвлөгөө өгөх 4.Багшийн нийгмийн идэвх -Идэвхтэй судлаач байх -Салбарын шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулах 5.Багшийн хамтын үйл ажиллагаа -Хөтөлбөрийн судалгаа, шинэчлэлд оролцох -Суралцагчдын гэр бүл, олон нийт,</p>
--	---	---	--	---	--	---	--

				-Өөрийн тухай мэдлэг	боловсруулах, хэрэгжүүлэх	-Суралцаг- чийн нас, хувийн онцлог, сонирхол, авьяас чадварыг харгалзах -Мэргэж- лийн ёс зүйн зарчмыг дагаж мөрддөг г.м.	сонирхлын бүлэгтэй хамтран ажиллах <u>Багш бие</u> <u>хүний</u> <u>шинжүүд</u> нь: - Хүсэл тэмүүлэлтэй Уран цэлмэг яриатай -Алиа хошин -Хөдөлмөрч -Нөхөрсөг -Шинэчлэгч -Идэвх зүтгэлтэй -Эх оронч
--	--	--	--	-------------------------	------------------------------	--	--

**Харьцуулан судалсан улс орнуудын шинэ багшийн стандартын нийтлэг ба ялгаатай тал**

Хүснэгт 2

Харьцуулсан зүйл	Нийтлэг тал	Онцлог ялгаа
Багшийн стандартыг боловсруулж хэрэглэсэн хугацаа	2000-2007 онд боловсруулж, хэрэглэсэн.	АНУ 1992 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд 2011 онд шинэчлэн боловсруулсан. Багш мэргэжлийн стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх талаар баялаг туршлага хуримтлуулсан орон.
Стандартын зориулалт, хэрэглээ	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багш бэлтгэх сургууль төгсөгч (teacher candidate) буюу шинэ багш (new/beginning teacher)-д багшлах эрх олгоход хэрэглэнэ.</li> <li>▪ Багш бэлтгэх сургуулийн багш боловсролын хөтөлбөрийн хүрээ, агуулгыг тодорхойлоход ашигладаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багш бэлтгэх сургуулийн бакалавр, магистрийн түвшний сэтгэл судлал – сурган хүмүүжүүлэх боловсролын агуулгыг шинэчлэхэд зориулагдсан (ОХУ).</li> <li>▪ Бакалаврын түвшний боловсролын сургалт (багш бэлтгэх) зохион байгуулах байгууллагад зориулагдсан (Монгол).</li> </ul>
Стандартын үүрэг	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багшийн анхан шатны боловсролын хөтөлбөрүүд (initial teacher education programs)-ийг боловсруулах жишиг/бэнчмарк болох</li> <li>▪ Багш болох гэж буй, багшийн ажлыг эхлэн хийж буй хүмүүст өөрсдийгөө мэргэжлийн хувьд хөгжүүлэх, чадавхижуулахад туслах хэрэглүүр болох (зарим орны стандартад хөгжих чиглэлийг илэрхийлэх гэх зэргээр томъёолсон)</li> <li>▪ Багш мэргэжлийнхээ тухайн түвшинд юуг хийж, гүйцэтгэхийг тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багшлахуйн хөгжлийн хэтийн чиг хандлагыг тогтоох (АНУ)</li> <li>▪ Багш бэлтгэх сургууль төгсөгчийн сурлагын амжилтыг илтгэх, тайлагнах хүрээг тогтоох (Шотланд)</li> <li>▪ Багш бэлтгэх сургуулийн багш боловсролын агуулга, сургалтын орчны нийтлэг шаардлагыг тогтоох (Монгол)</li> </ul>
Стандартыг	<ul style="list-style-type: none"> <li>▪ Үр дүнтэй багш (effective teacher)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багшийн үнэт зүйлст</li> </ul>

<p>боловсруулахад тулгуурласан “Багш”-ийн загвар</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Эргэцүүлэгч багш (reflective teacher)</li> <li>▪ Шинжлэн судлаач багш (inquiring teacher)</li> <li>▪ Шинэчлэгч багш (transformative teacher)</li> </ul>	<p>суурилсан загвар/V<sup>3</sup>SK model (Сингапур)</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Судлагдахуун (сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан)-д тулгуурласан (ОХУ).</li> </ul>
<p>Стандартыг боловсруулсан хүмүүс, байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Багш боловсролын судалгааны байгууллага, багш нарын холбоо, “багш боловсрол” судлаачдын нийгэмлэг, багш бэлтгэх их сургууль, коллежийн профессор багш нар, судлаачид</li> <li>▪ Дээд/багш боловсролын стандарт боловсруулах төслийн баг</li> </ul>	<p>Багш бэлтгэх их сургуулийн ректорын тушаалаар томилогдсон ажлын хэсэг (Монгол)</p>
<p>Багшийн стандартын бүтэц, агуулгын хүрээ</p>	<p>Багш боловсролын агуулгын дараах хүрээнд багш мэргэжилтэн бие хүний үнэт зүйлс, хандлага, мэргэжлийн мэдлэг, ойлголт мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагыг тодорхойлсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Суралцагч ба суралцахуй</li> <li>➢ Заах хичээлийн агуулгын мэдлэг ба хэрэглээ</li> <li>➢ Сургалтын арга зүй</li> <li>➢ Багш, багшлахуй</li> <li>➢ Багшийн мэргэжлийн хариуцлага ба манлайлал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Ерөнхий соёлын чадамж</li> <li>▪ Мэргэжлийн чадамж (ОХУ)</li> </ul>

### **Улс орнуудын шинэ багшийн стандартын агуулгын хүрээнд туссан нийтлэг сэдвүүд**

Шинэ багшийн (зарим оронд төгсөгчийн) стандартын агуулгын хүрээ нь багш бэлтгэх их сургууль, коллежуудын багш боловсролын хөтөлбөрийн агуулгаа бүтэцлэх, улмаар курс хичээлийн хөтөлбөрөө боловсруулах үндэс болж байгааг өмнө өгүүлсэн билээ.

Иймд бид өөрийн орны багш боловсролын агуулга, арга зүйг шинэчилж буй хэрэгцээний үүднээс судалж буй улс орнуудын шинэ багшийн стандартын (Япон, Финлянд зэрэг орны хувьд багшид тавьж буй шаардлага, эзэмшвэл зохих чадамжийг авч үзсэн) агуулгын хүрээнд туссан хамгийн нийтлэг сэдвүүдийг тодруулахыг зорьсон юм. Үүнд:

№	Нийтлэг сэдвүүд	АНУ	Англи	Шотланд	Сингапур	ХБНГУ	БНХАУ	ОХУ	Финлянд	Япон
1	Хувь суралцагчийн онцлог, хөгжил, ялгаатай байдал	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	Суралцах орчин	✓	✓	✓	✓	✓	✓		✓	✓
3	Заах хичээлийн агуулгын мэдлэг, түүний хэрэглээ	✓	✓	✓	✓	✓	✓		✓	✓
4	Эрдмийн/академик хэл	✓	✓	✓	✓		✓	✓	✓	
5	Үнэлгээ, хяналт шинжилгээ, санал зөвлөгөө/эргэх холбоо	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
6	Сургалтын төлөвлөлт (хөтөлбөр боловсруулах, төлөвлөх)	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
7	Сургалтын аргууд	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
8	Суралцах ба сургах үйл ажиллагаа	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
9	Харилцаа	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
10	Мэдээлэл харилцааны технологи	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
11	Багшийн мэргэжлийн үүрэг хариуцлага (тасралтгүй суралцах, хувь багшийн хөгжил,	✓	✓	✓	✓	✓	✓		✓	✓



	мэргэжлийн эргэцүүлэл)									
12	Багшийн мэргэжлийн ёс зүй	√	√	√	√	√	√	√	√	√
13	Боловсролын судалгаа (судалгааны үр дүнг хэрэглэх, судалгаа хийх)	√	√	√	√	√	√	√	√	√
14	Багшийн манлайлал, хамтын ажиллагаа	√	√	√	√	√	√		√	
15	Тогтвортой хөгжлийн боловсрол	√	√	√	√				√	
16	Боловсролын онол, зарчим, үзэл баримтлал, практик үйл ажиллагаа		√	√	√				√	√
17	Боловсролын хууль эрх зүй		√	√	√	√	√	√		√
18	Багшийн ажлын байрны бодлого, хамтын хариуцлага, оролцоо	√	√	√	√	√	√		√	√
19	Мэргэжлийн үнэт зүйл	√	√	√	√				√	√

## Улс бүрийн шинэ багшийн стандартын онцлог, авууштай туршлага

### 1. АНУ

АНУ-ын “багш” мэргэжлийн стандарт, тэр дундаа шинэ багшийн стандарт нь хамгийн олон жилийн түүхтэй, хэрэглээний баялаг туршлагатай стандарт юм. 1992 онд InTASC (Interstate Teacher Assessment and Support Consortium) буюу багшийг үнэлэх болон тэдэнд дэмжлэг үзүүлэх муж дундын консорциумаас **багшийн загвар стандартыг** гаргасан. Энэхүү загвар стандартад үндэслэн муж улс бүр шинэ багшид багшлах эрхлиценз олгох стандартыг боловсруулан мөрдөж иржээ. Эл шинэ багшийн стандарт нь багш бэлтгэх их сургуулиудад багш боловсролын хөтөлбөрийн агуулгын хүрээг тогтооход хэрэглэгддэг бол оюутанд ямар курс хичээлийг сонгож судлах шийдвэрээ гаргахад нь тус болдог практик ач

холбогдолтой баримт бичиг юм. Ази-номхон далайн бүс нутгийн олон орон уг стандартыг жишиг загвар болгон судалж, ашигласан туршлага ч буй. Дэлхийн банкны “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төслийн санхүүжилтээр 2007 онд Бээжин хотноо Олон улсын боловсролын солилцооны Хятадын судалгааны төвөөс зохион байгуулсан ” Үр дүнтэй боловсролын төлөө багш нарыг хөгжүүлж, удирдах нь” сэдэвт зүүн ази-номхон далайн бүс нутгийн орнуудын бага хуралд АНУ-ын дээрх стандартыг “багш” мэргэжлийн стандартыг хэрхэн боловсруулах үлгэр загвар болгон танилцуулж, туршлагаа хуваалцаж байсан билээ.

Энэхүү стандартыг шинэчлэн боловсруулж, 2011 оны 5-р сараас олон нийтэд танилцуулж, бүх нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж байна. Уг стандартыг боловсруулах ажлыг Америкийн багш боловсролын коллежуудын холбоо, Америкийн сургуулийн удирдлагуудын нийгэмлэг, Америкийн багш нарын холбоо, Америкийн боловсрол судлаачдын нийгэмлэг, Багшийн мэргэжлийн стандартын үндэсний зөвлөл, Багш боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл г.м 20 орчим мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагуудын төлөөлөл орсон комисс гүйцэтгэжээ. Энэ нь стандарт боловсруулах ажил мэргэжлийн түвшинд, олон талаас нь хэлэлцэх нээлттэй орчинд, олон янзын шүүлтүүрийг дамжин боловсронгуй болох нөхцлийг бүрдүүлсэн байна. Энэхүү туршлагыг бид цаашдаа стандарт боловсруулах ажилд судалж хэрэглүүштэй. Монголын багш нарын холбоо ч багшийг мэргэжлийн түвшинд бэлтгэх асуудалд үзэл бодлоо хуваалцана гэдэгт найдаж байна.

Энэхүү шинэчлэн боловсруулсан стандартын тайлбарт өмнөх хувилбараас ялгагдах онцлогуудыг тайлбарлажээ. Тухайлбал, эдгээр стандарт нь мэдлэг, хандлага, гүйцэтгэлийг багш нарын дадлага туршлагыгулам цогц болгож гүнзгийрүүлэх замаар дүрслэн харуулсан. Эдгээр гурван бүрдэл хэсгийн холбоо хамаарлыг дахин бүтэцчилж, **гүйцэтгэлийг** багшлах практикт ажиглаж, үнэлж болохоор зүйлийн нь хувьд **хамгийн эхэнд** авч үзсэн байна. Энэ нь Америкийн багшийн стандартыг бусад орныхоос ялгаж буй нэг онцлог мөн. Бусад бүрдэл хэсгүүдийн нэрийг өөрчилжээ. “Үндсэн мэдлэг” нь баримтын болон үйлдийн буюу хийх аргын тухай мэдлэгээс бүрдэнэ. Энэ нь практик үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг тодорхой илэрхийлсэн байна. “Нэн чухал хандлагууд” нь багш бодит байдал дээр хэрхэн хийж үйлдэхэд гүйцэтгэл чухал үүрэг/ рольтой болохыг тодруулсан мэргэжлийн үйл ажиллагааны хэвшил, ёс суртахууны үүргийг онцлон зааж байгаа аж.

Уг баримт бичиг дэх үгийн сонголт нь үзэл баримтлалтай холбоотой. Жишээ нь, “сурагч”, “оюутан” гэдэг үгийг “суралцагч” гэдэг үгээр сольжээ. “Суралцагч” нь “сурагч, оюутан” гэдгээс суралцах үйл явцад илүү идэвхтэй оролцогч гэдгийг далд утгаар илэрхийлнэ. Нөгөө талаас, суралцагч нь албан бусаар, хялбар дөт суралцах боломжтой хүн гэсэн санааг давхар илэрхийлдэг аж. Мөн “анги танхим” гэдэг нэр томъёог “суралцахуйн орчин” гэдэг үгээр сольжээ. Энэ нь зөвхөн танхимд бус, хаана ч сурах боломжийг олгоно гэсэн санааг илэрхийлж байгаа юм байна.

Энэхүү стандартыг хэрэглэхдээ багшлахуйн болон сургалтын асуудлыг хувьсан өөрчлөгдөх, интеграцчилагдсан үйл явц гэдэг талаас нь авч үзэхийг зөвлөжээ. Иймд эдгээр стандартад зарим талаар өөр хоорондоо давхцсан, уялдаатай зүйлүүд нилээд ажиглагдаж байв.

Зарим шинэ нэр томъёо, үг хэллэгийг тайлбарласан нь уг стандартыг ойлгох, хэрэглэх боломжийг нэмэгдүүлж өгсөн байв.Тайлбарыг хавсралтаас үзнэ үү.

## **2. АНГЛИ**

Стандарт нь “багш” мэргэжлийн түвшин болон багшид ямар ахиц гарч байгааг тодорхойлох боломж олгодог.

Багшийн мэргэжил эзэмшин тус мэргэжлээрээ сургуульд ажиллах гэж буй багш бүр Английн багшийн ерөнхий зөвлөл (АБЕЗ)-д заавал бүртгүүлэх ёстой. Багшийн мэргэжил эзэмшсэн бөгөөд дээрх зөвлөлд бүртгүүлсэн болохыг Шинэ багшийн сургалт хариуцсан байгууллага тодорхойлж өгнө.Тус байгууллага нь шинэ багшийн стандартад тухайн багш нийцэж байгаа эсэхийг тодорхойлох үнэлгээг хийдэг.Энэхүү үнэлгээгээр шинэ багшийн стандартыг хангасан хүн багшаар ажиллахаар томилогдоно. Энэ утгаараа шинэ багшийн стандарт нь бүхий л түвшний багшийн стандартын суурь болдог. Учир нь түвшин тус бүрийн стандарт нь өмнөх түвшний стандарт дээр суурилсан байна.

Стандартын цөм агуулга нь мэргэжилтэн бие хүний шинж, хандлагад тавих шаардлагыг хамгийн эхэнд авч үзсэн байв. Тухайлбал, хүүхдээс хүсэн хүлээж буй зэрэг хандлага, үнэт зүйлс, зан үйлийг багш өөрийн биеэр үлгэрлэн харуулдаг байх, ажлын байрны бодлого, үйл ажиллагааны талаар мэдлэгтэй, тэдгээрийг хэрэгжүүлэх хамтын хариуцлага хүлээхэд бэлэн, бусдын зөвлөгөөг авахад нээлттэй хандах гэх зэрэг шаардлага тавьжээ. Шинэ багш нарын хувьд мэргэжлийн хөгжлийн эхэн үед өөрт нэн тэргүүнд шаардлагатай зүйлээ тодорхойлж, түүнийгээ хангах үүрэг хариуцлага хүлээлгэсэн нь бусад улсын стандартаас онцлог байв.

Багшийн мэргэжлийн мэдлэг, ойлголтын хүрээнд мэдээлэл харилцааны технологийг сургалтын үйл ажиллагаандаа хэрхэн ашиглахаа мэддэг байх нь бусад орныхтой адил боловч багш бүр мэдээлэл харилцааны технологийн мэргэжлийн ур чадварын тест өгсөн байх шаардлага тавьсан нь бусад орноос ялгаатай байв.


Багшийн мэргэжлийн ур чадварын хүрээнд суралцахуйг үнэлэх, хяналт шинжилгээ\мониторинг хийх чадварт санал, зөвлөгөө (feedback) өгөх чадварыг нилээд онцлон үзсэн байна.Мөн суралцах орчны асуудлыг онцгойлон анхаарч, суралцах чиг зорилго бүхий таатай орчин бүрдүүлэх, сургуулиас гадуур суралцах боломжийг тодорхойлж чаддаг байх нь багш мэргэжилтний бас нэгэн чухал чадвар аж.

## **3. ШОТЛАНД**

Багш бэлтгэх сургууль төгсөгчид тавьж буй шаардлагад багш боловсролын хөтөлбөрийн бэнчмарк\жишиг шаардлагыг нийцүүлэн боловсруулсан нь судлууштай туршлага байв. Бусад орныхтой харьцуулахад, уг стандартын зориулалт, хэрэглэгчид нь

харьцангуй өргөн хүрээтэй байлаа.Тухайлбал, багш боловсролын курс хичээлүүдийн дизайныг хийх, батлах, магадлан итгэмжлэхэд, мөн уг хөтөлбөрийн хүрээнд хичээл заах багш нарт, хөтөлбөрийн мониторинг, үнэлгээ хийх хүмүүст, багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудад хэрэгтэй аж.

Багш боловсролын хөтөлбөрүүд нь багшийн мэргэжлийн хөгжлийн дараах гурван талыг хөхүүлэн дэмжих хэрэгтэй гэж үздэг байна:



Дүрслэл1

Багш боловсролын хөтөлбөрүүд нь дээрх гурван хүрээний харилцан үйлчлэлийн үр дүн болж боловсрогдох ёстой.Хөтөлбөр бүрийн онцлогоос хамаарч аль нэг талыг нь илүүтэй анхаарах авч, гурван талыг аль алийг нь хөгжүүлэхийг санал болгодог байна.

#### 4. СИНГАПУР

Сингапур нь өмнө өгүүлсэн Брисбаны санаачлагад 2006 онд нэгдсэн Ази-номхон далайн бүс нутгийн 27 орны нэг билээ.Бүс нутгийн хэмжээнд хэрэгжсэн “багш” мэргэжлийн стандарт боловсруулах, энэ талаар туршлагаа хуваалцах судалгааны төсөлд идэвхтэй оролцсон байдаг.Уг судалгааны тайланд дурдсанаар, Сингапур улс нь 2001 оноос “багш” мэргэжлийн стандартыг боловсруулан хэрэглэж иржээ.

2004 онд Сингапурын Боловсролын Үндэсний хүрээлэн багш бэлтгэх хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, үнэлсэн байна.Шинэ багш нарын эзэмших эрхэм чанаруудыг үнэт зүйлс, ур чадварууд, мэдлэгийн хүрээ гэсэн бүтэцтэйгээр шинэчлэн боловсруулжээ.

Багш бэлтгэх асуудлыг авч үзэхдээ багш бэлтгэх сургалтыг онцолдог уламжлалт хандлагаас татгалзаж, “багш боловсрол”-д онцгой ач холбогдол өгч, бүтэцчилсэн хүрээгээ (хүснэгт-11-ээс харна уу) боловсруулан гаргажээ. Тэгэхдээ дараах хандлагыг чиг баримжаа болгосон нь “багш” мэргэжлийн стандарт боловсруулах бидний цаашдын ажилд үнэ цэнэтэй туршлага болно гэж үзэж байна. Үүнд:

- “Шинжээчдийн зөвшилцлийг бүрдүүлэх” хандлага: Багш боловсролын асуудлаар зөвлөгөө өгч чадах бодлого боловсруулагчид ба мэргэжилтнүүдийн бүлгийг орон нутгийн болон олон улсын түвшинд бүрдүүлсэн байна. Шинжээчдийн мэдлэг,

туршлагыг багш мэргэжилтний, ялангуяа багш бэлтгэх сургууль төгсөгчийн чанарыг хэмжих үзүүлэлт/индикаторыг зөвшилцөхөд ашиглажээ. Эдгээр үзүүлэлтийг багш бэлтгэх хөтөлбөрийг үнэлэхэд ч бас хэрэглэж байна.

- “Судалгаанд тулгуурласан” хандлага: Багш бэлтгэх болон суралцахуйн тэргүүн туршлага, дэвшилтэт загваруудын талаар бичигдсэн сүүлийн үеийн бүтээл, сурвалжуудыг гүнзгий судалжээ. Эл үйл явц нь багш боловсролын шинэ чиг хандлага, анхаарал татаж буй асуудалд төвлөрөхөд тус болсон байна. Тухайлбал, сурган хүмүүжүүлэх агуулгын мэдлэг (pedagogical content knowledge), боловсролын суурь мэдлэг, багшлах дадлагын загварууд, чанарын хяналт ба үнэлгээ гэх мэт зүйлсийг шинээр авч үзсэн байна.
- “Мэргэжлийн зөвшилцөл”-ийн хандлага: Гол түншүүд (боловсролын яам, багш бэлтгэх сургуулийн багш нар, оюутан багш нар)-ийн зөвлөгөөг авсан. Тухайлбал, сургуулийн захирлуудын шинэ багш нарт байвал зохих шинж чанарын талаар өгсөн ярилцлага, санал бодлыг нь авч ашигласан байна.

Багш, боловсролын ажилтнуудад өөрсдийгөө мэргэжлийн хувьд хөгжүүлэх, үндсэн чадваруудаа сайжруулахад нь туслах хэрэглэгдэхүүн болох гүйцэтгэлийг нэмэгдүүлэх менежментийн тогтолцоог Сингапурын боловсролын яамнаас бодлоготойгоор боловсруулж, хэрэгжүүлсэн нь уг стандартыг үр дүнд хүргэхэд нөлөөлжээ. Энэхүү тогтолцоо Сингапурын сургуулийн менежментэд 2003 оноос нэвтэрсэн аж. Энэ нь мэдлэг, чадвараас гадна мэргэжилтэн бие хүний чанарыг шаарддаг чадамжид суурилсан гүйцэтгэлийн менежментийн тогтолцоо юм (Сингапурын боловсролын яам, 2004).

Багшийн үнэт зүйл, ур чадвар, мэдлэгийн бүтэцчилсэн хүрээг багшийн чанар, багш нарын ажлын мөн чанарт гарч буй өөрчлөлт, багшид тавьж буй шинэ шаардлага зэрэгт төвлөрүүлэн боловсруулсан байна. Шинэ багшийн зайлшгүй эзэмших ур чадвар, мэдлэгийн бүрдэл хэсгүүдийг сургалтын хөтөлбөрт шингэсэн гол үнэт зүйлсийн хамт өргөн утгаар илэрхийлжээ.

Энэхүү бүтэцчилсэн хүрээний тусламжтайгаар хөтөлбөрүүдийг боловсруулахдаа шинжлэн судлах, шинэчлэл, эргэцүүлэл, харилцан хүндэтгэл, хувь хүний холбоо, хамтын ажиллагаа, олон нийт зэрэг ойлголтуудыг онцлон авч үзсэн байна.

Энэхүү бүтэцчилсэн хүрээ нь оюутан багшид багшлахуйн үнэт зүйлээ эргэцүүлэх, практик үйл ажиллагаа, Сингапур сургуульд багшилж, бас суралцахад нь зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэт зүйлээ хөгжүүлэхэд нь туслах стратеги/арга зам, сурган хүмүүжүүлэх арга барилд тулгуурлан боловсруулсан байна.

Шинж чанар бүр мэргэжлийн практик үйл ажиллагааны тодорхой нэг хэсгийг онцлон харуулж байгаа боловч шинж чанарууд өөр хоорондоо давхцаж, зарим талаар бие биенээсээ харилцан хамаарсан, уялдаа холбоотой байв.

## 5. ХБНГУ

“Багш” мэргэжлийн стандартыг ХБНГУ-ын муж улсуудын Соёлын сайд нарын байнгын

бага хурлаар хэлэлцэж, 2004 оноос мөрдөж эхэлсэн түүхтэй.

Соёлын сайд нарын бага хурал нь сургалт, боловсролын чанарыг дээшлүүлэх гол зорилгыг тодорхойлж, боловсрол эзэмших таатай нөхцлийг бүрдүүлэх, цаашид хөгжүүлэх чухал хүчин зүйл бол стандартыг мөрдөж, хянах явдал хэмээн үзсэн байна. “Багш” мэргэжлийн стандартууд нь багш нарын мөрдөх шаардлагатай дүрэм журам гэж тодорхойлсон нь бусад орноос ялгаатай байв. Уг стандартын удиртгал хэсэгт багшийн үйл ажиллагааны мөн чанарыг дараах байдлаар тодорхойлсон байв. Үүнд:

1. *Багш нар сургах, сурах үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн хүмүүс*

Багш нарын гол зорилго бол зорилго чиглэлтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй сургах, сурах үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, тусган хүртэх, түүнчлэн тогтмол үнэлэхэд оршино. Багш мэргэжилтний чанар нь тэдний ажлын гүйцэтгэл буюу хичээлийн чанарт нөлөөлдөг.

2. *Суралцагчдыг хүмүүжүүлэх зорилго нь хичээл болон сургуулийн амьдралтай нягт холбоотой болохыг багш нар ойлгож ухамсарласан байна.*

Эцэг эхтэй илүү ойр хамтарч ажилласнаар энэхүү зорилго сайн биелэх болно. Хоёр тал харилцан ойлголцож, хүмүүжлийн асуудал доголдол, сурах бэрхшээл үүсэх тохиолдолд хамтран асуудлыг шийдвэрлэх бүтээлч арга замыг эрж хайхад бэлэн байх ёстой.

3. *Багш нар хичээл болон цаашид боловсрол, мэргэжил эзэмшихэд үнэлгээ, зөвлөгөө өгөх ажлыг хариуцлагатай хийж гүйцэтгэнэ.* Энэ нь багшийн үүрэг/рольд гарсан үндсэн өөрчлөлттэй холбоотой аж.

4. Багш нар мэргэжлийнхээ үйл ажиллагаанд шинэ хандлага, шинжлэх ухааны сүүлийн үеийн ололт амжилтыг тусгаж ажиллах зорилгоор *өөрсдийн чадамжийг байнга хөгжүүлж, мэргэжил дээшлүүлэх, үргэлжлүүлэн суралцах боломжийг ашиглана.* Багш нар бусад байгууллагуудтай хамтран ажиллана.

5. Багш нар сургуулийн хөгжил, *суралцахуйг дэмжсэн сургуулийн соёл болон өдөөн дэмжсэн суралцах уур амьсгалыг* бүрдүүлэхэд оролцоно. Гадаад болон дотоодын төсөл, үнэлгээний ажилд оролцоход бэлэн байна.

Эдгээр таван чанар нь “багш” мэргэжлийн стандартын цөм агуулгад шингэсэн байв. Стандартын агуулгын хүрээг онолын ба практик үйл ажиллагаанд тавих шаардлага гэсэн бүтэцтэйгээр боловсруулсан нь багшийн мэргэжлийн чадамжид суурилсан бусад орны бүтцээс ялгаатай боловч үндсэн мэдлэг, чадварын элементүүдийн сонголт адил төстэй байв. Багшийн үнэлж дүгнэх, хяналт шинжилгээ хийх, суралцагчдад санал зөвлөгөө өгөх чадварт тавьсан шаардлага нь явцын ба үр дүнгийн үнэлгээний тэнцвэрийг хангах, үнэлгээний олон төрлийн аргаас сонголт хийж хэрэглэх чадварыг хөгжүүлэхийг баримжаалсан байсан нь цаашид анхаарч судлууштай туршлага гэж үзэж байна.

## **6. ОХУ**

Холбооны улсуудын мэргэжлийн дээд боловсролын стандартын “Сэтгэл зүй – сурган хүмүүжүүлэх боловсрол” чиглэлийн төслийг Оросын боловсролын академи, Москва хотын захиргаагаар батлагдсан Москва хотын их дээд сургуулиудын ректоруудын зөвлөл, Оросын шинжлэх ухааны академийн сэтгэл судлалын хүрээлэн, Оросын боловсролын академийн сэтгэл судлалын хүрээлэн, М.В. Ломоносын нэрэмжит

Москвагийн улсын их сургуулийн сэтгэл судлалын факультет гэх зэрэг судалгааны байгууллагуудын төлөөлөл бүхий төслийн баг боловсруулж, 2009 онд олон нийтээр хэлэлцүүлсэн<sup>2</sup> байна.

Стандартын төслийн хүрээнд чадамжид суурилсан загварыг боловсруулан гаргасан ба түүний мэргэжлийн зорилтуудыг сэтгэл зүй сурганы чиглэлд нийтлэг байхаар тодорхойлон, эдгээр зорилтуудыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай ерөнхий соёлын болон мэргэжлийн чадамжийг бакалавр ба магистрын түвшинд тодорхойлсон байв.

## **7. БНХАУ**

Багшийн мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадвар, сургалтын үйл ажиллагаанд хандах ажлын хариуцлагыг чанаржуулах замаар суралцагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилго бүхий таван бүрдэл хэсэгтэй (хүснэгт11-ээс харна уу) багшийн стандартыг бүх үндэстний боловсролын стандартын товчооноос 2007 онд батлан гаргасан байна.Стандартын зөвлөмжид багш хүнд байвал зохих бие хүний чанаруудыг тодорхойлсон бөгөөд хөдөлмөрч шургуу чанар, шинэчлэгч, боловсролын үйлчилгээний мэдрэмжтэй нөхөрсөг чанар, эх оронч үзлийг эрхэмлэн дээдэлсэн нь бусад орны стандартаас ялгагдах онцлог шинж юм.

Энэхүү стандарт боловсруулах ажилд БНХАУ-ын боловсролын яам, Боловсролын судалгааны Хятадын үндэсний хүрээлэнгээс Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэй 2007, 2008 онуудад зохион байгуулсан олон улсын бага хурлууд хувь нэмрээ оруулсан байна.

## **8. ФИНЛЯНД**

Бидний энэ удаагийн судалгаанд хэдийгээр “багш” мэргэжлийн албан ёсны стандартыг нь эх сурвалж болгон авч харьцуулаагүй боловч тус улсын судалгаанд тулгуурласан багш боловсролын бодлого, түүнийг хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хүрээнд багшид тавьж буй шаардлагыг судалсан юм. Эл судалгааны үр дүнгээс толилуулья.

Багш нар бол боловсролын шинэчлэлийн гол хөдлөгч хүч бөгөөд тэд мэргэжлийн өндөр, бүтээмжит чадамжуудыг эзэмшсэн байх шаардлагатайгаас гадна тэдгээрийг нь хянан шинжлэх хэрэгтэй гэж үздэг юм байна. Багшийн заавал эзэмших чадамжуудыг академик, сурган хүмүүжүүлэх, соёлын чадамж хэмээн гурван бүлэгт ангилан үзэж байсан уламжлалт хандлагадаа шүүмжлэлтэй хандах болжээ.Багшийн чадамжийн талаар судалсан бүтээлүүдэд шинжилгээ хийж, багшийн мэргэжлийн чадамжийг дахин тодорхойлох олон удаагийн оролдлогын үр дүнд дараах шинэ чадамжуудыг тодорхойлон гаргажээ.

### *Дүрслэл2*

---

<sup>2</sup><http://www.herzen.spb.ru/main/structure/others/umo/>



**Академик чадамж**(field competencies) нь “**Сургуульд юу заах ёстой вэ?**” гэсэн асуултад илүүтэй хамаарна. Тэдгээр нь **судлах хичээлийн агуулга, түүний академик судалгааг** багтааж байдаг багшийн мэргэжлийн чухал чадамж юм.Нэг талаар багшийн заах, нөгөө талаар суралцагчийн судлах хичээлүүдтэй холбоотой чадамж юм.Багш нар агуулгыг дамжуулах үүрэг хариуцлага хүлээдэг уламжлалт үзэл баримтлалд, академик чадамжийг тухайн шинжлэх ухааны салбарын гол онол, үзэл баримтлалд тулгуурласан хамгийн чухал чадамж гэж үздэг байсан. Заах зүйлээ мэддэг байх тухай үзэл баримтлал, багш анги танхим дахь суралцах үйлийг хариуцна гэсэн ойлголт цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдсөөр байна. Энэхүү өөрчлөлтийн хүрээнд багшийн академик чадамжийг, ялангуяа агуулгыг дамжуулах үйлтэй холбон авч үзэх явдал багасч, харин суралцагчдад **агуулгатай ажиллахад нь зөвлөн туслах үүргийг** илүү чухалчлах болж байна.

**Судалгааны чадамж** (research competencies) нь судалгааны арга, техникүүд, багшлах ажлын явцад хийх судалгаагаа төлөвлөх, хийж гүйцэтгэх дэд чадамжуудыг агуулна.Эл чадамж нь сургалтын хөтөлбөрийн болон боловсролын судалгааг сонирхож буй хүмүүс, мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ. Судалгааны чадамж нь багш нарт салбарынхаа хөгжилд хувь нэмрээ оруулах, түүгээрээ дамжуулан өөрсдийгөө хөгжүүлэхэд нөлөөлдөг байна. Түүнчлэн, суралцагчдын шинжлэх ухааны сэтгэлгээ, ур чадварыг нэмэгдүүлэхэд ч ач тустай.Судалгааны чадамж нь багшийн бүх талын чадамжийг хөгжүүлэхэд туслаад зогсохгүй багш боловсролын шинэ чиг хандлага болох **судалгаанд тулгуурласан багш боловсролыг** дэмжинэ.Уг чадамжийг хэр эзэмшсэн нь багшийн (ялангуяа төгсөгч, шинэ багшийн) мэргэжлийн ба судалгааны бүтээлийг уншихад бэлтгэгдсэн байдлаар илэрнэ.Багш унших зүйлээ сонгож чаддаг, уншиж буй зүйлээ үнэлдэг, уншсан зүйлээс нь чухам юу нь тэдний практикт хэрэг болохыг мэддэг байх шаардлагатай.



**Сургалтын хөтөлбөрийн чадамж** (curriculum competencies) нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон хэрэгжүүлэх гэсэн хоёр дэд чадамжаас бүрдэнэ. Хөтөлбөрийн чадамж нь сургалтын хөтөлбөрийн философийн мэдлэг, сургалтын хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, хөтөлбөрийн элементүүд, хөтөлбөр боловсруулах загварууд, түүний гүйцэтгэлийг төлөвлөх арга замууд, хөтөлбөрийн агуулгыг сонгох, зохион байгуулах, боловсруулах үйл явц, багшлах үйлээ төлөвлөх, хөтөлбөр боловсруулах судалгаанд бэлтгэх, нөхцөл байдлыг хянах ур чадваруудаас бүрдэнэ. Сургалтын хөтөлбөрийн чадамж нь багшлах ба суралцах үйл явцыг хөтөлбөрт төлөвлөх үйлтэй нягт холбоотой. Нөгөө талаар, эдгээр чадамж нь багш нарт багшлах үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэх залуур болдог. Хөтөлбөрийн чадамж нь нэг талаас онолын, нөгөө талаас практик чадамжуудтай нягт холбогдоно. Түүнчлэн суралцахуй ба багшлахуйтай холбоотой чадамж болохынхоо хувьд багшийн мэдлэг, ур чадварын хүрээг тодорхойлдог. Хөтөлбөрийн чадамжийг эзэмшихгүйгээр, сургуульд боловсролын үйлчилгээг үр өгөөжтэй үзүүлэх боломжгүй гэж үздэг байна. Финляндын сургалтын хөтөлбөрийн төвлөрсөн бус тогтолцоотой холбоотой нэгэн онцлог бол багш бэлтгэх сургууль төгсөгч нь сургуулийн түвшний сургалтын хөтөлбөрийн төлөвлөлтөд оролцоход бэлтгэгдсэн байх шаардлагатай аж. Үүний тулд мэргэжлийн буюу шинжлэх ухааны хэлээр харилцах, хамтын эргэцүүлэл хийх чадварыг бас эзэмшсэн байна.

**Тасралтгүй суралцах** (lifelong learning) үйл явц нь суралцагчдаас суралцах үйл ажиллагааныхаа хариуцлагыг өөрсдөө хүлээхийг шаарддаг. Хувь хүнийхээ хувьд багш нар нь өөрсдийн тасралтгүй суралцах үйл явцыг хариуцна. Тасралтгүй суралцах чадамж нь **сурахуйд суралцах чадварууд** болон **мэргэжил дээрээ өсч хөгжих багш нарын хариуцлагаас** бүрдэнэ. Эдгээр чадамж нь суралцах чадвар хийгээд амьдралынхаа турш суралцах үйл явцаа улам сайжруулахад суралцах арга, хэрэгслийг ашиглах ур чадвартай шууд хамааралтай. Тасралтгүй суралцах чадамж нь багш өөрийн суралцах үйл явцаа хариуцах чадвар, мөн суралцагчдын насан туршдаа суралцах чадварыг хөгжүүлэх чадваруудыг багтаана. Өөрөөр хэлбэл, тасралтгүй суралцахуй нь хоёр гол чадвараас бүрдэж байна. Нэг нь багш өөрөө амьдралынхаа турш суралцах чадвар, нөгөө нь суралцагчдынхаа насан туршийн чадварыг хөгжүүлэх багшийн хариуцлага юм.

**Сэтгэл хөдлөлийн чадамж** (emotional competencies) нь багш нар болон суралцагчдын үнэт зүйл, ёс суртахуун, итгэл үнэмшил, хандлага, зовнил/сэтгэлийн түгшүүр, сэдэл, бусдын сэтгэлийг ойлгох чадвар зэргийг агуулна. Тэдгээр нь сургуулийн хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сургалтын хөтөлбөрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэгтэй нягт холбоотой. Багш нарын сэтгэл хөдлөлийн чадамж нь суралцагчдын сурахуйд дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой. Учир нь багш суралцагчдын суралцахуйн сэтгэл хөдлөлийн талыг хэрхэн хөгжүүлэхээ мэдэж байвал тэдний суралцах дур сонирхолд ч нөлөөлнө. Эдгээр чадамж нь багшид суралцагчдынхаа суралцах үйл ажиллагаанд хяналт тавьж чадах үр бүтээлтэй багш болоход нь тусална. Суралцахуй нь сургалтын үйл явцад эерэг хандах мэдрэмжийг буй болгодог сэтгэл хөдлөлийн дэмжлэгүүдийг шаарддаг. Багш нь суралцагчдынхаа суралцах үйл ажиллагаанд зөвлөгөө өгдөг зөвлөх/ментор байх ёстой.

**Нийгэм-соёлын чадамж** нь суралцагчид болон багш нарын нийгэм-соёлын нөхцөл байдал, орон нутгийн болон үндэсний, олон улсын үнэт зүйлс, ардчилал, хүний эрхийн асуудлуудын талаархи мэдлэг, бусадтай багаар хамтарч ажиллах хийгээд нийгмийн судалгааны чадварыг багтаана.Энэ бүгд нь суралцагчид болон багш нарт сургалтын үйл явцын эрх чөлөөг олгож, суралцахуйг идэвхжүүлдэг.Хувь хүн нь нийгмийн амьдралд нийгмийн төдийгүй соёлын хувьд оршин байдаг.Ийм маягаар суралцахуй ба суралцагчдын нийгэм соёлын нөхцөл байдлын хооронд нягт холбоо хамаарал буй болдог.Суралцахуйн зарим онолд суралцахуйг нийгэм-соёлын нөхцөл байдал/контекст талаас нь авч үзээд, багш нарын нийгэм соёлын чадамж нь суралцагчдын суралцах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд тусална гэж үздэг.Хүмүүнлэгийн болон нийгмийн онолуудыг багш нарын нийгэм-соёлын чадамжийг хэрэглэх замаар л анги танхимын практикт хэрэгжүүлэх боломжтой.

**Харилцааны чадамж** нь харилцааны загварууд, багш, суралцагчид, нийгмийн орчин, суралцах сэдвүүдийн хүрээн дэх харилцан үйлчлэлийг агуулна.Багш нар аман харилцааны чадамж болон биеийн хэл, мэргэжлийн хэлээ эзэмшсэн байх шаардлагатай.Харилцааны чадамж нь дуу хоолой, биеийн хэл, үг яриа, хүртэх, харааны контакт, бичгийн хэрэглээ зэргийг хамарна.Тэдгээр нь хүмүүс хоорондын харилцааны чадвар болон хүний дотоод/ өөрөө өөртэйгээ харьцах үйл явц, сонсох, ажиглах, ярих, асуух, задлан шинжилгээ хийх болон үнэлэх чадварыг агуулна.

**Мэдээлэл харилцааны технологийн** – ICT чадамж нь мэдлэг олж авах, дамжуулах хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн хэрэглээнд тулгуурладаг. Тэдгээр нь мэдээллийг боловсруулах, хэрэглэх, хадгалах, харилцах, түгээх үйл ажиллагаанд тус болох аливаа технологийг агуулна.МХТ-ийн чадамжууд нь мэдээллийг хэрэглэх, харилцахад зориулагдсан бүхий л технологийг хамрах **мэдээллийн менежмент болон мэдээлэл боловсруулах технологийн хэрэглээтэй** нягт холбоотой.Энэ нь МХТ-ийн чадамж нь сургалтын үйл явц дахь харилцааг идэвхжүүлэхэд хичнээн чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

**Хүрээлэн буй орчны чадамж** (environmental competencies) нь экологи, хүрээлэн буй орчны аюулгүй байдлын чадамж юм.Экологийн буюу хүрээлэн буй орчны асуудал нь багшийн тогтвортой хөгжлийн нэгэн хэмжигдэхүүн мөн. Хүрээлэн буй орчныг цэвэр, амьдрах боломжтой байлгах, экологийн нөөцийн менежмент, эко системийн тухай ойлголт, байгалийн нөөцийг боломжид нь тохируулан ашиглах болон нөөцийн боломжит байдал гэх мэт **экологийн систем болон хүрээлэн буй орчны тухай мэдлэг, хандлага, ур чадварыг** хүрээлэн буй орчны чадамж хэмээн тодорхойлж байна.

## 9. ЯПОН

“Багш” мэргэжлийн стандарт байхгүй боловч багшид тавих шаардлагыг тодорхойлсон хэд хэдэн чухал баримт бичгийг Японы Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас гаргасан байна. Тухайлбал, тус яамны бага, дунд боловсролын хороо, багшийн асуудал эрхэлсэн хэлтсээс гаргасан “Багшаас шаардах мөн чанар ба ур чадвар”,

“Багшлах эрх олгох хуулийг хэрэгжүүлэх журам” зэрэг нь бусад орны “багш” мэргэжлийн стандарттай адил үүрэг гүйцэтгэж буй баримт бичгүүд юм. Багшаас дараах мөн чанар ба ур чадварыг шаардаж байна:

- Сурган хүмүүжүүлэгч хүний хувьд үүргээ ухамсарлах
- Хүүхдийн, ер нь хүний өсөлт хөгжлийн талаар гүнзгий ойлголттой байх
- Хүүхдийг хайрлан энэрдэг байх
- Заах хичээлийн мэргэжлийн өндөр мэдлэгтэй
- Өргөн баялаг соёлтой
- Багшийн ажил мэргэжилдээ хайртай, түүгээрээ бахархдаг
- Хичээл заах, сурагчдыг удирдан чиглүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагатай

Дунд сургуулийн багшид тавих шаардлагыг хүмүүнлэг ба мэргэжлийн чанар гэсэн хоёр хүрээнд авч үзсэнийг хүснэгтээс харна уу.

Хүснэгт 4.

Хүмүүнлэг чанарт	Мэргэжлийн чанарт
<p><b>1.Хүүхдийн төлөө сэтгэлтэй байх</b> Энэ нь хүүхдийг ойлгодог мэргэжилтний төдийгүй, хувь хүнийхээ хувьд багшийн заавал эзэмших ёстой чанар юм. [Энэ чанарыг эзэмшихэд багшлах дадлагын өмнө хийдэг асаргааны дадлага хувь нэмрээ оруулдаг. Багш боловсролын хөтөлбөрийн удирдамжид зааснаар, окутан багш бүр асрамжийн аль нэг байгууллагад 7 хоног хүн асрах дадлага хийх ёстой аж]</p>	<p><b>1. Суурь, үндсэн мэдлэг, чадвар эзэмшсэн байх</b> <u>Ярих</u> а. Хурд, дууны хэмжээ (чанга сул), байрлал, байдал зэргээ тохируулж ярих б. Хүүхдэд ойлгогдохоор дунд нь зогсолттой ярих в. Уялдаа холбоотой ярих ба давталт, нэмэлт гэх мэтээс татгалзах г. Хүүхдийн сэтгэл зүрхэнд хүрч, харилцан ойлголцохоор ярих <u>Асуух</u> а. Зааж байгаа зүйлдээ тохирсон асуулт тавих б. Олон талаас нь харах, олон талаас нь бодуулахуйц асуулт тавих в. Асуулт асуусны дараа хүлээх г. Хүүхдийн үзэл бодлыг чухалчилж, багшийн санаа зорилгыг шууд тулгахгүй байх д. Асуултыг заавар, зөвлөгөө, чиглүүлэлт зэргээс ялгаж салгах <u>Хүүхдүүдээс хариулт авах</u> а. Алдаатай хариу, багшийн санаа зорилгод нийцээгүй хариуг ч сонсох, үзэл бодлыг нь гүнзгийрүүлэх түлхүүр болгон ашиглах б. Хүүхдийн хариултыг дуустал нь сонсох в. Хүүхдийн өөртөө хэлсэн зүйл, бувтнасан</p>

	<p>зүйлийг ч анхаарах  г. Санаа бодлыг гүнзгийрүүлэх, өөрчлөх, өргөжүүлэх боломж бүхий хариуг чухалчлах  д. Хүүхдийн хариуг дураараа өөрчлөхгүй, хүчилсэн дүгнэлт хийхгүй байх  <u>Самбарт бичих</u>  а. Хүүхдийн харах боломж (самбарын харагдац, өндөр гэх мэт)-д тохируулж бичих.  б. Үсгийн хэмжээ, зурлагын дараалал, ханзны ард бичигддэг хэсэг зэргийг анхаарч, тод нямбай бичих  в. Хүүхдийн самбарт бичсэн зүйл, бүтээсэн бүтээл зэргийг ашиглах  г. Шохой, карт, жижиг самбар зэргийг ашиглах  д. Самбар ашиглалтын бүтцийг судалж, бодлоо гүнзгийрүүлэн, цэгцэлж сургалтыг үр нөлөөг сайжруулахад анхаарах.</p>
<p><b>2.Сэтгэл санаагаа тогтворжуулж, мэдрэмжтэй байх</b>  Сэтгэл санаа тогтвортой байснаар хүн мэдрэмжтэй байж чаддаг. Багшийн сэтгэл санаа тогтвортой байх нь хүүхдийн сэтгэл санаа тогтвортой байх, сургалтын агуулгыг ойлгох, хувь хүн өсч хөгжихөд ч ихээхэн нөлөөлдөг.</p>	<p><b>2.Хүүхдийг ойлгох</b>  Хүүхдийг ойлгохын тулд “өөрийн туршлагад хэт итгэж найдахгүй байх” ба “өөрийгөө ойлгох ойлголтыг гүнзгийрүүлэх” гэсэн тодорхой харах цэг хэрэгтэй. Хүүхдийг ойлгож, таньж мэдэх олон арга байдаг. Гэвч хүүхдийг хүнийх нь хувьд ойлгож таньж мэдэхийн тулд багш өөрийгөө хүнийх нь хувьд харж, хүн болсон өөрийнхөө талаархи ойлготыг гүнзгийрүүлэхгүй бол хүүхдийг ойлгож, танин мэдэх боломжгүй.</p>
<p><b>3. Өөрийгөө хөгжүүлэхийг эрмэлзэх</b>  Багш ч хувь хүнийхээ хувьд өөрөө өсөж хөгжихийг эрмэлзэх хүсэл тэмүүлэл, хандлагатай байхгүй бол хүүхдийн өсөлт, хөгжилд хувь нэмэрээ оруулж, хүүхдэд өөрөө өөрийгөө өөрчлөхөд нь тусалж дэмжиж чадахгүй. Багшийн өсөж хөгжихийг эрмэлзэх зүрх сэтгэл нь өдөр тутам харилцаж байгаа хүүхдэд маш их нөлөөлнө.</p>	<p><b>3.Сайн хичээл бүтээх</b>  -Сайн хичээл бүтээхийн тулд багш үндсэн, суурь мэдлэг, чадварыг эзэмших  -Хүүхдийг сайн танин мэдсэний үндсэн дээр хичээлийн мөн чанарыг ухамсарлах, сургалтын материалыг задлан шинжлэх, бүтээх  -Сургалтын үйл ажиллагаа, сургалтын хэлбэр зэргийг шинээр бүтээх сэтгэлтэйгээр хичээлийг төлөвлөх</p>

## 10. МОНГОЛ УЛС

Багшлах эрх олгох, багшийн мэргэжлийн түвшинг тодорхойлох зориулалттай “багш” мэргэжлийн стандарт байхгүй. Дээр дурдсан улс орнуудад багшлах эрхийг шинэ багшийн стандартыг хангаж буй эсэхэд үндэслэн олгодог бол манай улсад багш бэлтгэх сургууль төгсөөд багшлах эрхийн гэрчилгээ авахаар ерөнхий боловсролын сургуульд багшилж буй дадлагажигч багш (шинэ багш)-ийг магадлан итгэмжлэхдээ БСШУ-ны сайдын 2008 оны 74-р тушаалд үндэслэж байна. ЕБС-ийн багшийн стандартыг боловсруулж, 2010 оноос мөрдөж эхэлсэн боловч уг стандарт нь багш болох гэж буй хүнд гэхээсээ багш бэлтгэх сургууль-байгууллагад илүүтэй зориулагдсан. Уг стандарт нь багш бэлтгэх “дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны бие даасан байдлыг хангаж, сургалт олон хувилбартай байх нөхцлийг бүрдүүлэх”<sup>3</sup> зорилготой аж.

Гэхдээ энэхүү стандартад “Ерөнхий боловсролын сургуулийн багш” мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн бэлтгэлд тавих шаардлагыг тусгаж өгсөн нь бусад орны төгсөгчийн\шинэ багшийн стандарттай харьцуулах боломжийг олгосон юм. Багаар хоршин ажиллах, мэдээллийн технологийг ашиглах, тасралтгүй суралцах зэрэг төгсөгчийн бэлтгэлд тавих нийтлэг шаардлагын зарим нь бусад орны стандартад мөн адил тусгагдсан нийтлэг зүйлс байна. Төгсөгчийн мэргэжлийн бэлтгэлд тавих үндсэн шаардлага нь **мэдлэг, чадвар** гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрджээ. Харин бусад орны шинэ багшийн\төгсөгчийн стандарт нь багш болох гэж буй хүний (teacher candidate) эзэмшвэл зохих хандлага, үнэт зүйлс (Сингапур зэрэг орны хувьд түүнд суурилсан), ур чадвар, мэдлэгийг үндсэн бүрдэл хэсэг болгож авсан байсныг өмнөх хэсэгт дурдсан.

АНУ, Англи, Сингапур зэрэг орны стандарт нь үр дүнтэй суралцахуй, багшлахуйн талаар хийсэн сүүлийн үеийн судалгааны ололтод тулгуурлан олон шинэ ойлголтуудаар баяжсаныг өмнө өгүүлсэн билээ. Эдгээр шинэ ойлголтыг илэрхийлж буй нэр томъёог адилхан хэрэглэж байгаа боловч, утга санаа нь өөр байна. Тухайлбал, суралцагчийн өвөрмөц ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах асуудлыг зөвхөн суралцагчийг ялгаварлан гадуурхахгүй, тэгш хамруулан сургахтай (5.3.2.5) холбон авч үзсэн байх жишээтэй. Гэтэл үүний цаана, суралцагчийн өсч торнисон нийгэм-соёлын орчин, хуримтлуулсан амьдралын туршлага, суралцах хэв шинж, хурд гэх мэт зүйлсийн ялгаа, өвөрмөц онцлог нь суралцах үйл явцад нөлөөлдөг гэдгийг багш хүлээн зөвшөөрч, ойлгох санаа агуулагдаж байдаг. Дээрх орнуудын багшийн стандартад явцын болон үр дүнгийн үнэлгээний тэнцвэрийг хангах, тоон ба чанарын үнэлгээний аргыг хослуулан хэрэглэх шаардлага тавигдсан бол манай стандартын 5.3.3.4-т хичээлдээ суралцагчийн хөгжлийг **бодитой үнэлэх орчин үеийн аргыг** хэрэглэх мэдлэг, чадвар эзэмшихийг шаарджээ. Ямар арга бодитой хэмжилтийг хийж чадах нь юуг хэмжих вэ гэдэгтэй илүү холбоотой. Орчин үеийн арга гэдгээр төгсөгч юуг ойлгох нь ч тодорхойгүй байна. Багш болох гэж буй хүн тухайн шинжлэх ухааныхаа эрдмийн\академик хэлийг бүрэн эзэмшсэн байх, мэргэжлийн хэлэлцүүлэг, эргэцүүлэл, улмаар судалгааны ажилд бэлтгэгдсэн байх шаардлагыг дээрх орнууд стандарт болгон тавьжээ. Манай ЕБС-ийн багшийн стандартын 5.3.1.2-д төгсөгч нь боловсролын стандарт хөтөлбөрийн дагуу суралцагчдад заах хичээлийнхээ бичиг үсгийн боловсролыг бүрэн эзэмшсэн байна гэжээ. Эдгээр нь нэг

<sup>3</sup>Монгол улсын стандарт. Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: Ерөнхий боловсролын сургуулийн багш. MNS 5323-95: 2009. Стандартчилал, Хэмжил зүйн газар. УБ. 2009. х. 1.

зүйлийг хэлээд байна уу, эсвэл ялгаатай ойлголтууд уу эргэн харах шаардлагатай болов уу.Энэ мэтчилэн төгсөгчийн мэдлэг, чадварт тавьж буй шаардлагатай холбоотой олон зүйлийг дахин нягтлах, мэргэжлийн түвшинд хэлэлцэх хэрэгцээ ажиглагдаж байв.

### **Судалгаа 3: Багшлах эрх олгохтой холбоотой эрх зүйн орчинд хийсэн судалгаа:**

Багшлах эрх олгох шалгалтын зорилго, агуулга нь энэ чиглэлээр тухайн үед мөрдөгдөж байгаа дүрэм, журамтай зохицох ёстой гэж бид үзсэн учир зохих судалгааг хийсэн.

БШУЯ: САЙДЫН ТУШААЛ, № А/305 2013-08-15 “Багшид багшлах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хасах журам” –ын тухай “Багшлах эрх олгох, хасах журам батлах тухай” 2008 оны 74 дүгээр тушаалыг хүчингүй болгосон. Зарим заалтыг тодруулбал:

- Багшлах эрхийг багш мэргэжлийн чиглэл бүрээр олгоно. Багшлах эрх нь дараах хоёр төрөл байна.
- 1.4.1. Боловсролын байгууллагад эхний нэг жил ажиллах эрх. Энэ нь багш мэргэжлээр **шинээр төгсөгч** болон боловсролын байгууллагад **гурваас дээш жил ажиллаагүй багшид** боловсролын байгууллагад **нэг жилийн хугацаатай ажилах** эрх олгохыг ойлгоно.
- 1.4.2. Багшлах эрх. Энэ нь боловсролын байгууллагад **эхний жилдээ ажилласан багшид** цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багшлах **эрх олгохыг** ойлгоно.

Багшид багшлах эрх олгоход дараах тусгай шалгуур үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

- 2.2.1. Сургалтын байгууллагад нэг хичээлийн жил ажилласан байх;
- 2.2.2. Эхний жил ажиллаж буй багшид зориулсан үндсэн сургалтад хамрагдсан байх
- 2.2.3. Ажиллах хугацаандаа хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үр дүнд хийсэн өөрийн үнэлгээ, дүгнэлт;
- 2.2.4. Ажиллах хугацаанд харьяалагдсан заах аргын нэгдлийн өгсөн үнэлгээ, дүгнэлт

**Зөвлөмж: Багшлах эрх олгох шалгалтын агуулгыг боловсруулахдаа одоогоор хүчин төгөлдөр байгаа дээрх дүрэм, журмын заалтуудыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна.**